



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



МОНГОЛЫН
КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО

ХОХИРЛЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ
ТОГТОЛЦООНЫ ХАРЬЦУУЛСАН
СУДАЛГАА

ЦУВРАЛ СУДАЛГАА №4



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



МОНГОЛЫН
КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО

ХОХИРЛЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ
ТОГТОЛЦООНЫ ХАРЬЦУУЛСАН
СУДАЛГАА

ЦУВРАЛ СУДАЛГАА №4

Улаанбаатар хот
2021 он

ННА 67.408
ДАА 345
Х-514

Судлаачид:

Г.ОЮУНБОЛД, Хууль зүйн ухааны магистр, Монголын Хуульчдын Холбооны гишүүн, хуульч

Б.БАТЗОРИГ, Хууль зүйн ухааны доктор, Монголын Криминологичдын Холбооны ТУЗ-ын дарга

Х.ЭРДЭМ-УНДРАХ, Хууль зүйн ухааны доктор, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал

С.НОМЫНБАЯСГАЛАН, Хууль зүйн ухааны магистр, Монголын Криминологичдын Холбооны судлаач

О.АНУДАРЬ, Монголын Хуульчдын Холбооны Олон улсын эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, хуульч

Г.ДАГВАСҮРЭН, Статистикийн ухааны магистр, судлаач

О.ХУЛАН, Статистикийн ухааны магистр, судлаач

М.ӨҮЛЭН, Сэтгэл судлалын магистр, судлаач

Г.БАТДӨЛГӨӨН, Эрх зүйч, судлаач

Судалгааны хүрээнд гарсан дүгнэлт, санал нь зөвхөн судлаачдын үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форум болон бусад байгууллагын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9990-5-6

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	5
УДИРТГАЛ.....	6
НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ.....	10
1.1 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулах талаарх Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээний зохицуулалт	10
1.2 Хохирогчийн эрхийг сэргээх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах талаарх НҮБ-аас баталсан олон улсын бусад хэм хэмжээ	11
1.3 Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах талаарх Европын холбооны стандарт	13
ХОЁР. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ ТОГТОЛЦОО.....	25
2.1. Гэмт хэргийн хохирол барагдуулахтай холбоотой үндсэн хуулийн зохицуулалт.....	25
2.2. Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх тогтолцоо	28
2.3. Гэмт хэргийн хохирлын сан	48
2.4 Гэмт хэргийн хохирол, хор уршгийг нөхөн барагдуулах үйл ажиллагаа.....	53
ДҮГНЭЛТ	66
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	76
НОМ ЗҮЙ	78

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Европын холбооны нөхөн сэргээх үйлчилгээний стандарт	23
Хүснэгт 2.1. Улс орнуудын гэмт хэргийн хохирол барагдуулах, нөхөн төлөх сан.....	50
Хүснэгт 2.2. Улс орнуудын гэмт хэргийн хохирол, хор уршиг барагдуулах талаар гомдол гаргах эрх, хугацаа, хэмжээ хязгаар.....	54
Хүснэгт 2.3. Улс орнуудын гэмт хэргийн хохирол, хор уршгийн нөхөн төлбөр авах субъект, нөхөн төлбөрийн төрөл.....	57
Хүснэгт 2.4. Улс орнуудын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох үнэлэх, түүнийг олгох субъект.....	61
Хүснэгт 3.1. Шүүх шинжилгээний тухай өмнөх ба шинээр батлагдсан хуулийн харьцуулалт	71

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 2.1. ХБНГУ-ын хохирогчийг хамгаалах эрх зүйн тогтолцоо.....	26
График 2.2. Унгар Улс дахь хохирогчийг дэмжих үйлчилгээ	37
График 2.3. Хохирол нөхөн төлүүлэх процесс	57

ӨМНӨХ ҮГ

Манай улсад өрнөж буй эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үндсэн чиглэлийн нэг нь хохирогч хамгаалах, хохирол барагдуулах тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх явдал билээ. Гэмт хэргийн хохирол, хор уршгийг шударгаар барагдуулах нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх төдийгүй, нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй үр нөлөөтэй тэмцэхэд чухал нөлөөтэй. Иймд Нээлттэй Нийгэм Форум нь хохирол барагдуулах тогтолцоог бүрдүүлэхэд ач холбогдол бүхий цуврал судалгааны төслийг Монголын криминологичдын холбоотой хамтран хэрэгжүүлж байна.

Тус холбооны судлаачдын эрхлэн гүйцэтгэсэн “Гэмт хэргийг хохирол барагдуулах тогтолцооны харьцуулсан судалгаа” нь “Хохирлын үндэсний тогтолцоо” цувралын дөрөвдөх дугаар болж уншигчдын гарт хүрч байна. Энэхүү судалгааг Г.Оюунболд ахлагчтай судалгааны баг олон улсын гэрээ, конвенцод туссан зохицуулалт болон ХБНГУ, Польш, Унгар, Эстони, Гүрж, Япон, БНСУ, Канад, ОХУ зэрэг улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хохирол барагдуулах зохицуулалтыг судлан, санал, зөвлөмж боловсруулжээ.

Нээлттэй Нийгэм Форум хохирлын үндэсний тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэхэд хувь нэмэр болох үүднээс бодлогын судалгаа, хэлэлцүүлэг, хууль тогтоомжийн шүүмж, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа зэрэг олон талт ажлыг зохион байгуулсан бөгөөд бодлого боловсруулагчид, гүйцэтгэгч нарт агуулга, арга зүйн хувьд дэмжлэг болно гэж найдаж байна. Бидний боловсруулж, нийтэлсэн судалгааны ажлууд болон энэ чиглэлд хэрэгжүүлсэн бусад үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас авч танилцан, түгээн дэлгэрүүлэхийг хүсье.

ННФ-ын Гүйцэтгэх Захирал П.Эрдэнэжаргал

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 2-р бүлэгт хүний эрх, эрх чөлөөг тусгайлан баталгаажуулж, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн тунхаглан зааж өгсөн. Энэ хүрээнд Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил 2012 оноос эхэлж, өнөөг хүртэл үргэлжилж байна.

Монгол Улс 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг УИХ-аас баталснаас хойш хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах, хууль сахиулах болон шүүхийн тогтолцоог үе шаттайгаар боловсронгуй болгох ажил хийгдсээр байна¹. Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн шинэтгэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгохоос гадна сэжигтэн, яллагдагч төвтэй эрүүгийн процессоос хохирогч төвтэй эрүүгийн процесст шилжих шаардлагатай нь нийгэм ба хүмүүсийн өөрчлөгдөж буй хандлагаас ажиглагдах боллоо. Монголын криминологичдын холбооны Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилттэйгээр 2020 онд хийсэн “Хохирлын үндэсний тогтолцоо бүрдүүлэх нь” судалгааны тайланд гэмт хэргийн хохирол барагдуулах үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зарим гадаад орны эрх зүйн зохицуулалт, тогтолцоог тусгайлан судлах шаардлагыг дурдсан байдаг.

Тиймээс гадаад орны гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцоо, сургамж, сайн туршлагыг судлан, хэрхэн хөгжиж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх, гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог боловсронгуй болгох шаардлагыг харгалзан үзэж тус судалгааг хийв.

¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн болон хавсралт тайлан, 2016.

Зарим гадаад оронд шүүхийн өмнө (хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаа) болон шүүхийн (ял шийтгэл оногдуулах болон эрүүгийн хэргийг шийдвэрлэж дууссаны дараах) шатанд хохирлыг үнэлж, хохирлын мөнгөн дүнг тодорхойлж буй байдал, түүний нөхөн төлөлтийг зохицуулсан эрх зүйн орчныг харьцуулан судлах нь энэхүү судалгааны ажлын зорилго болно. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Зарим гадаад орны гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцоо, эрх зүйн орчныг судлах;
2. Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцод туссан хохирогчийн эрхийг хамгаалах, хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой зохицуулалтыг судлах;
3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэж буй сайн туршлага болон алдаа дутагдлыг судлах;
4. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын төрөл, хэмжээг тогтоох, үнэлэх, шийдвэрлэх, нөхөн төлүүлэх үр дүнтэй эрх зүйн тогтолцоог нэвтрүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах.

Сэдвийн хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хийсэн “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол” судалгааны тайланг² дурдаж болно. Тус судалгаагаар гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлж чадахгүйд хүрч буй байдлын учир шалтгааныг авч үзсэн байна. Ингэхдээ АНУ, Англи, ХБНГУ, Япон, ОХУ-ын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсан хэдий ч 2007 оны судалгаа учир гадаад улсуудын сүүлийн үеийн туршлагыг 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай уялдуулан харьцуулан судалж, одоогийн эрх зүйн орчинд нийцсэн санал, дүгнэлт боловсруулах хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

Түүнчлэн Хүний эрхийн үндэсний комиссоос 2013 онд хийсэн

² Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, 2007.

“Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт” дүн шинжилгээнд³ Ази, Европын нийтлэг эрх зүйн системтэй улсуудаас нийт 10 улсыг сонгон товч судалсан байдаг.

Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр 2021 оноос эхлэн хэрэгжиж байгаа Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх хөтөлбөрийн хүрээнд эдийн бус хохирол тэр дундаа сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх талаар судлаач А.Түвшинтөгс, Д.Ганхүрэл, Э.Золзаяа нарын хийсэн “Сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэлтэй хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийн практик, харьцуулсан дүн шинжилгээ”, Б.Ариунзаяа, Л.Амгаланбаатар нарын хийсэн “Эдийн бус хохирол нөхөн төлүүлэх тогтолцооны талаарх онолын асуудал ба монгол улсын шүүхээр эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж буй байдал” судалгааны тайланг дурдаж болно. Дээрх судалгааны тайланд⁴ Монгол Улс дахь гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоож, үнэлж, шүүхээр нөхөн төлүүлж буй байдалд дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлсэн нь шинэлэг болсон. Ийнхүү сүүлийн 10 гаруй жил хийгдэж байгаа судлаачдын бүтээл, нийтлэлүүд нь 2023 онд шинээр батлагдсан Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, батлахад голлох эх сурвалжууд болсныг дурдах нь зүйтэй юм.

Энэхүү судалгаагаар ХБНГУ, Польш, Унгар, Эстони, Гүрж, Япон, БНСУ, Канад, ОХУ-ын эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, харьцуулан судлав. Сонгон авсан улс орнууд нь манай улсын эрүүгийн эрх зүйн хохирол, хор уршиг нөхөн төлүүлэх тогтолцоотой ойролцоо, эх газрын эрх зүйн бүлд хамаардаг ба эрх зүйн хувьд баримжаалан хөгжиж байгааг харгалзан сонгож авсан болно. Судалгааны зорилтод нийцүүлэн тухайн улс орнууд

³ Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт, Суурин дүн шинжилгээ, 2013. <https://bit.ly/38w95dA>

⁴ https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Court%20Series%204_Web.pdf

хохирол нөхөн төлүүлэх тогтолцоо бүрдүүлэхдээ олон улсын гэрээ, конвенцыг хэрхэн харгалзан үзсэнийг мөн судаллаа. Судалгааны эх сурвалжид англи, орос, япон, солонгос хэлээр бичигдсэн цахим орчин дахь эрх зүйн акт, бусад бүтээлийг ашигласан. Түүнчлэн гэмт хэргийн хохирол, хохирол нөхөн төлүүлэх албан ёсны статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийв. Мөн холбогдох байгууллагын албан ёсны цахим хаягаас эх сурвалжийг нягталж үзлээ.

Судалгааг хууль зүйн ухааны доктор, профессор Б.Батзориг, хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах, хууль зүйн магистр Г.Оюунболд, С.Номынбаясгалан, судлаач О.Анударь, М.Өүлэн, Г.Дагвасүрэн, О.Хулан, Г.Батдөлгөөн нарын бүрэлдэхүүнтэй гүйцэтгэлээ.

НЭГ.

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг барагдуулах ажиллагааг зарим гадаад оронд хэрхэн зохицуулсан талаар харьцуулан үзэхийн өмнө Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд хэрхэн тусгасан талаар товч авч үзье.

1.1 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРЖ, СОЁРХОН БАТАЛСАН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй” гэж, мөн пактын 14 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ” гэж; Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Оролцогч улс бүр энэхүү Конвенцод хамаарах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох болон хохирлыг арилгах талаар зохих журмыг батална” гэж; Эрүүдэн шүүх болон

бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 14 дүгээр зүйлд “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй. Энэхүү зүйл нь хохирогч буюу бусад этгээд дотоодын хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр авах эрхийг хөндөхгүй” гэж тус тус гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулсан байна.

Тус гэрээ, конвенцод нэгдэн орсон орон дээрх эрхийг дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулах үүрэг хүлээдэг. Мөн зарим гэрээ, конвенцын хэрэгжилтийн талаар оролцогч улс тогтмол хугацаанд илтгэл хүргүүлэх үүрэг хүлээдэг бөгөөд тухайн гэрээний дагуу байгуулагдсан Хороо илтгэлийг хэлэлцэж, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар зөвлөмж хүргүүлдэг. Хүний эрхийн талаар хүчин чармайлт гаргаж, хүний эрхийн наад захын стандартыг тогтооход эдгээр баримт бичиг гол эх сурвалж болдог. Нөгөө талаас энэ нь олон улсын өмнө гэрээгээр хүлээсэн үүрэг юм.

1.2 ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ СЭРГЭЭХ, ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ ТАЛААРХ НҮБ-ААС БАТАЛСАН ОЛОН УЛСЫН БУСАД ХЭМ ХЭМЖЭЭ

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн A/RES/40/43 тогтоолоор баталсан Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглалд зааснаар хохирогч гомдлоо хэрхэн барагдуулах, хэрхэн хамгаалуулах талаар мэдэх боломжтой байхаас гадна, шүүх ажиллагаанд оролцох шаардлага, ямар эрх, үүрэгтэй оролцох талаар болон шүүхийн урьдчилсан ажиллагаа, шүүх

ажиллагааны хугацаа, дараалал, явц болон үр дүнгийн талаар мэдээллээр хангагдах эрхтэй. Түүнчлэн шүүхийн болон захиргааны журмаар хохирлоо барагдуулах тохиолдолд түүний бүх эрхийг танилцуулах ба эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийн талаар мэдээлэхээс гадна тэдгээрийг ашиглах боломжоор хангах ёстой. Тусгай зорилтот сан байгуулах, хэрэв тус сан нь хохирлын хэмжээг бүрэн барагдуулах боломжгүй бол энэ зориулалтаар нэмэлт сан байгуулах төрийн үүргийг тус Тунхаглалд заасан байна. Хохирол барагдуулах албан, албан бус механизм нь хялбар, хэрэгжих боломжтой байхаас гадна шударга, зохих судалгаанд үндэслэгдсэн, өртөг, чирэгдэл багатай байх ёстой. Хохирогчийн хохирлыг барагдуулахаас гадна түүний гэр бүлийн гишүүн, халамжид нь буй бүх хүмүүс нөхөн төлбөр авах эрхээр хангагдах ёстой.⁵

Түүнчлэн тус Тунхаглалын 11-д төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байна. Тухайн хохирлыг хариуцах Засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулахаар заасан. Энэхүү зарчим, стандарт нь эрүүгийн процесс ажиллагааны үед хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгоход ихээхэн ач холбогдолтой төдийгүй, шударга ёсны зарчмыг хангах, олон улсын стандартыг хэрэгжүүлэх үндэс болдог. Хохирогчийг хамгаалахтай холбоотой зохицуулалтын онцлогийг тодорхойлох зорилгоор НҮБ тус тунхаглалд зарим ойлголтыг тодорхойлсон. Үүнд:

- Гэмт хэргийн хохирогч: “НҮБ-ын гишүүн орнууд хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулийнхаа дагуу буюу эрх мэдлээ урвуулан, хэтрүүлэн ашигласан үйлдлийн улмаас бие

⁵ Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал: Судалгааны тайлан, 2010, 38 – 39 дэх тал.

махбод, сэтгэл санааны дарамтад орсон санхүүгийн алдагдал хүлээсэн эсвэл үндсэн эрх нь ноцтойгоор зөрчигдсөн зэрэг хор уршиг, хохирол учирсан хүнийг хэлнэ.” гэжээ.

- Нөхөн олговор: Гэмт этгээд буюу түүний өмнөөс хариуцлага хүлээх гуравдагч этгээд нь хохирогч, түүний гэр бүлийн гишүүн, асрамжид байсан хүмүүсийн хохирлыг шударгаар барагдуулна. Нөхөн олговор гэдэгт эд хөрөнгийг эргүүлж өгөх, учруулсан гэмтэл, хохиролд нөхөн төлбөр төлөх, хохирогч болсонтой холбогдсон зардлыг нөхөх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх, зөрчигдсэн эрхийг нь сэргээх зэргийг ойлгоно.
- Нөхөн олговрыг гэм буруутай этгээд төлөх боломжгүй буюу эх үүсвэр тодорхойгүй бол төрөөс нэн тэргүүнд:
 - a. Эрүүл мэндийн хүнд хохирол учирсан буюу сэтгэцийн эрүүл мэнд удаан хугацаагаар алдагдсан;
 - b. Гэмт хэргийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон, нас барсан хохирогчийн гэр бүлийн гишүүн, асрамжид байсан хүнд мөнгөн хэлбэрээр нөхөн олговор олгоно.
- Тусламж, дэмжлэг: Хохирогчид нөхөн олговроос гадна шаардлагатай эд материалын, эмнэлгийн, сэтгэл зүйн, нийгмийн халамжийн тусламжийг төрийн болон орон нутгийн эх үүсвэрээс олгохыг зөвлөсөн байна.

1.3 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ ТАЛААРХ ЕВРОПЫН ХОЛБООНЫ СТАНДАРТ

Европын холбооны гишүүн орнууд Европын холбооны хууль тогтоомжид үндэсний хууль тогтоомжийг зохих ёсоор нийцүүлэх үүрэгтэй. Европын холбоо нь гишүүн орнуудынхаа хохирлын тогтолцоог сайжруулах, хохирогчдын эрхийг нөхөн сэргээх чиглэлээр тусгайлсан стратегийн үзэл баримтлалыг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү стратегийн гол зорилго нь Европын холбооны аль ч улсад, ямар ч нөхцөл байдалд байхаас үл хамааран

гэмт хэргийн хохирогчдын эрхийг бүрэн дүүрэн хангах⁶ явдал бөгөөд гэмт хэргийн хохирогчдыг чадавхжуулах, хохирогчдын эрхийн төлөө хамтран ажиллахад оршино. Энэхүү стратеги нь таван үндсэн тэргүүлэх чиглэлийг баримталдаг. Үүнд:

- хохирогчтой үр дүнтэй харилцах, хохирогчдын зүгээс гэмт хэргийн талаар мэдээлэх аюулгүй орчин;
- эмзэг бүлгийн хохирогчдод үзүүлэх дэмжлэг, хамгаалалтыг сайжруулах;
- хохирогчдод нөхөн төлбөр авах боломжийг олгож, процессыг хөнгөвчлөх;
- холбогдох бүх оролцогчдын хамтын ажиллагаа, зохицуулалтыг бэхжүүлэх;
- хохирогчдын эрхийн олон улсын хамгаалалтыг бэхжүүлэх.

Европын холбооноос 2004 онд баталсан удирдамжаар гишүүн орнуудад дараах үүргийг хүлээлгэсэн.

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТОГТОЛЦОО⁷ **12 дугаар зүйл**

1.1.1. Энэхүү баримт бичигт заасан үндэстэн дамнасан гэмт хэргийн хохиролд нөхөн төлбөр авах журам нь өөрийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хүч хэрэглэсэн, санаатай гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай гишүүн орнуудын тогтолцоонд үндэслэн үйлчилнэ.

1.1.2. Гишүүн бүх улс орон өөрийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн санаатай үйлдсэн хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тогтолцоог бий болгож, хохирогчдод шударга, зохих нөхөн олговрыг олгохыг үндэсний хууль тогтоомжид тусгана.

⁶ European Commission. <https://bit.ly/3ywqH3B>

⁷ COUNCIL DIRECTIVE 2004/80/EC of 29 April 2004 relating to compensation to crime victims, <https://bit.ly/3ysBDze>

Ийнхүү Европын холбооноос үүрэг болгосон энэхүү баримт бичгийн 12-р зүйлд зааснаар Европын холбооны гишүүн улс бүр санаатай үйлдсэн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох үндэсний схемийг бий болгох шаардлагыг тавьсан байна.⁸

1.3.1 Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай Европын конвенц

Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчдын хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэх тухай Европын Зөвлөлийн 1983 оны конвенцод⁹ зааснаар нөхөн олговрыг бусад эх үүсвэрээс бүрэн авах боломжгүй бол Засгийн газар дараах субъектэд нөхөн төлбөр олгохоор заасан. Үүнд:

1. Санаатай үйлдэгдсэн, хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд нь хүнд хохирол учирсан хүмүүс;
2. Дээрх гэмт хэргийн улмаас амь нас нь хохирсон хүний гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс.

Дээр дурдсан нөхөн төлбөрийг нутаг дэвсгэр дээр нь гэмт хэрэг үйлдэгдсэн улс төлөх бөгөөд үүнд конвенцын оролцогч улсуудын харьяат иргэн, гэмт хэрэг үйлдэгдсэн улсад байнга оршин суудаг Европын Зөвлөлийн бүх гишүүн улсын иргэн хамарна. Нөхөн төлбөрт тухайн хүний орлого, эрүүл мэндийн үйлчилгээний зардал, оршуулгын зардал, асран хамгаалагчийн хувьд олох ёстой байсан орлого зэргийг хамруулж байна. Ингэхдээ үндэслэлтэй гэж үзвэл нөхөн олговор олгох дээд болон доод хязгаарыг тогтоож, тэрхүү тогтсон хэмжээнээс хэтэрч болохгүйг тусгасан. Нөхөн төлбөр авахаар өргөдөл гаргасан өргөдөл гаргагчийн санхүүгийн байдлыг харгалзан нөхөн төлбөрийг бууруулах эсвэл нөхөн олгож болохгүй үндэслэл илэрсэн, хохирогчтой хамааралгүй этгээд болох нь тогтоогдвол нөхөн төлбөр олгохоос татгалзаж болдог.

⁸ European Union, <https://bit.ly/3gRJHnk>

⁹ Council of Europe. European Convention on the Compensation of Victims of Violent Crimes. (1983) <https://bit.ly/3t0RLaa>

1.3.2 Гэм буруутай этгээдээс нөхөн төлбөр авах эрх, нөхөн төлбөрийн хэлбэр¹⁰

Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөрийг янз бүрийн хэлбэрээр олгодог. Европын зарим оронд эрүүгийн процессын аль ч шатанд гэмт этгээд хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр олгох боломжтой байдаг. Эрүүгийн процесс ажиллагааны явцад яллагдагч, шүүгдэгчээс гэмт хэргийн хохирогчид хохирол нөхөн төлөхийг үүрэг болгох зохицуулалттай улс орнуудад энэхүү шийдвэрийг боломжит богино хугацаанд, шүүхээс оногдуулах шийтгэлийн нэг хэсэг болгон гаргадаг.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдээс хохирогчид нөхөн төлбөр төлүүлэх олон янзын “хөшүүрэг” байдаг. Хэрэв яллагдагч, шүүгдэгч их хэмжээний мөнгөн дүнгээр тогтоосон хохирлыг нэг дор төлж чадахгүй тохиолдолд график тогтоох замаар нөхөн барагдуулах боломжийг олгодог. Энэхүү удаан үргэлжилсэн процесс нь хохирогчийн сэтгэл санаанд таагүй байдлыг үүсгэдэг бөгөөд төлбөрөө бүрэн авах хугацаа хойшилдгоос гадна хохирлыг хэсэгчлэн төлөх бүрд гэмт хэрэг үйлдэгдэх үеийн нөхцөл байдалд ахин ордог. Иймд гэмт хэргийн хохиролд хамаарах бүх нөхөн төлбөрийг хохирогчид төрөөс урьдчилан олгох боломжийг шийдвэрлэх шаардлагатай гэж Европын зөвлөлөөс гишүүн орнуудад зөвлөжээ.

Хэрэв эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлөх үүрэг хүлээсэн гэмт этгээд төлбөр төлөх эсвэл тодорхой хугацаанд тогтоосон хуваарийн дагуу төлөх боломжгүй бол хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлэх ёстой гэж зөвлөдөг. Жишээлбэл, Европын улсуудад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулахдаа автоматаар шууд дебит шилжүүлэг хийх боломжтой байх бөгөөд ингэснээр гэм буруутай нь тогтоогдож, хохирол нөхөн төлөх

¹⁰ Victim Support Europe, The Criminal Justice Programme of the European Union. Handbook for Implementation of Legislation and Best Practice for Victims of Crime in Europe. (2013) <https://bit.ly/3DDcdm8>

үүрэг хүлээсэн этгээд шууд тэр дор нь төлөх шаардлагагүй гэсэн үг юм. Гэмт этгээд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг тогтоосон хугацаанд төлөхөөс татгалзсан тохиолдолд тухайн этгээдийн данснаас шууд мөнгийг шилжүүлэх боломжийг шийдэх ёстой. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хохирлоо нөхөн төлөхөөс зайлсхийхийн тулд шүүхийн өмнөх үе шатанд өмч хөрөнгөө бусдад шилжүүлэх эрсдэлтэй гэж үзвэл мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны үеэр яллагдагчийн хөрөнгийг битүүмжлэх, хураан авах арга хэмжээ авах шаардлагатай. Энэ нь гэмт этгээд гэм буруутай нь тогтоогдвол хохирогч нөхөн төлбөр авах баталгааг хангахын тулд авч буй арга хэмжээ юм.

Хохирогчдын хувьд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зүгээс уучлал гуйх, хохирол хор уршгийг барагдуулах амлалт өгөх, түүнийг нөхөн төлөхөө илэрхийлэх нь чухал ач холбогдолтой. Хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлыг тогтоож, түүнийг арилгах талаар идэвхтэй арга хэмжээ авах, нөхөн сэргээх нь үр дүнтэй, шалгарсан арга болно. Европын Холбооны улсуудад тухайн улсын эрүүгийн хэргийн шүүхээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулахаар нөхөн олговор тогтоогдсон даруид хохирогч тухайн төлбөрийг цаг алдалгүй авах эрх үүсдэг. Энэ үеэр гэмт хэргийн хохирол, хор уршгийг барагдуулах асуудлаар гэм буруутай этгээдтэй харилцах боломжийг хязгаарладаг ба энэ нь хохирогчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үздэгтэй холбоотой.

Европын Холбооны хэд хэдэн улс гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийг тогтоосон хэмжээгээр урьдчилан авах боломжийг хохирогчид олгодог. Гэмт хэрэг үйлдсэн хүн төлбөрийн чадваргүй бол тухайн улсын эрүүгийн хэргийн шүүхээс хохирлын хэмжээг тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэн даатгалын эсхүл хохирлын санд төвлөрсөн мөнгөн хөрөнгөөс хохирогчид урьдчилан олгодог зохицуулалттай. Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэхээр гаргасан шүүхийн шийдвэрийг шүүгдэгч, ялтан сайн дураараа эсхүл шүүхээс тогтоосон хуваарийн дагуу биелүүлж

байгаа тохиолдолд даатгалын болон хохирлын сангаас хохирол барагдуулахгүй. Тус сангаас гэмт хэргийн хохиролд барагдуулсан мөнгөн хөрөнгийг шүүхээс гэм буруутай нь тогтоогдсон хувь хүн, хуулийн этгээдээс нөхөн гаргуулж, төвлөрүүлдэг зохицуулалттай.

Хохирогчийн хөндөгдсөн эрхийг сэргээх чиглэлээр Европын Холбооны Зөвлөлөөс 2004 онд гаргасан удирдамжийн хүрээнд Европын Холбооны улс орнууд тодорхой алхам хийх үүрэг хүлээдэг бөгөөд үүнд нийцүүлэн хууль, журам боловсруулж, хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад зөвлөжээ.

1.3.3 Төрөөс олгох нөхөн олговор¹¹, нөхөн олговрын сан

Өмнө дурдсанчлан Европын Холбооны орнууд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж дууссаны дараа гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулахаар нөхөн төлбөр олгох өөр өөр зохицуулалттай байдаг. Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийг гэм буруутай хүн, даатгалын компани эсвэл олон нийтийн нөхөн олговрын сангаас олгох зэргээр тус тусын тогтолцоонд хамаарах хувилбараар шийдвэрлэдэг.

Европын холбооноос гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийг баталгаажуулахын тулд “Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчийн хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэх тухай” 1983 оны конвенцод нийцүүлэн 2004 онд Гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох тухай 2004/08/ЕС дугаартай удирдамжийг баталсан. Энэхүү удирдамжаар Европын холбооны гишүүн улсын оршин суугч өөр гишүүн улсад үндэстэн дамнасан гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд нөхөн төлбөр олгох асуудлыг зохицуулсан ба гишүүн орнууд дотоодын хууль тогтоомжоо удирдамжид нийцүүлэх ажлыг хийсээр байна. Гэмт хэргийн хохирогч нөхөн төлбөр авах хүсэлтээ өөрийн оршин суугаа улсад эсвэл гэмт

¹¹ Victim Support Europe, The Criminal Justice Programme of the European Union. Handbook for Implementation of Legislation and Best Practice for Victims of Crime in Europe. (2013) <https://bit.ly/3DDcdm8>

хэрэг үйлдэгдсэн улсын шүүх, эрх бүхий бусад байгууллагуудад гаргах боломжтой. Европын Холбооны гишүүн орон нөхөн төлбөр авах хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үүрэг бүхий эрх бүхий байгууллага байгуулах үүрэгтэй.

Гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох тухай 2004/08/ЕС удирдамжаар Европын холбооны бүх гишүүн оронд нутаг дэвсгэртээ үйлдэгдсэн хүч хэрэглэсэн, санаатай гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тогтолцоог бүрдүүлэх үүрэг хүлээлгэдэг. Энэхүү тогтолцоо нь хохирогчдод нөхөн олговрыг зүй зохистой, шударгаар олгоход чиглэнэ. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд нөхөн олговор авахад тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хүч хэрэглэсэн, санаатай гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухайн орны журам үйлчилнэ. “Шударга”, “зохистой” нөхөн олговор гэж юу болох талаар оновчтой тодорхойлолт байхгүй боловч олон улсын гэрээнд нийцүүлэн хохирлыг нөхөн барагдуулах үйл явц нь үр дүнтэй, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг бодитой тогтоосон, хохирогчид учирсан хохирол, хор уршгийг бодитой тогтоож түүнийг арилгахад чиглэсэн байх шинжийг харгалзан үздэг. Гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, нөлөөлсөн хүчин зүйлийг тооцоолохдоо нэн тэргүүнд дараах зүйлийг анхаарна. Үүнд:

- Бие махбодын болон сэтгэл санааны хохирол;
- Ажил эрхлэлт, боловсрол, нийгмийн халамж үйлчилгээтэй холбоотой олох ёстой байсан орлого, бодит боломж;
- Эдийн болон эдийн бус хөрөнгийн хохирол, олох ёстой байсан орлого (алдагдал, алдагдсан боломж);
- Ёс суртахууны хохирол;
- Хууль зүйн болон шинжээчийн туслалцаа, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн халамж, үйлчилгээнд шаардагдах зардал.

Европын Холбооны Зөвлөлийн дээрх удирдамжийн хүрээнд гэмт хэргийн хохирогчдод дэмжлэг, туслалцаа үзүүлэхдээ гэмт хэрэг үйлдсэн иргэний харьяалал, гэмт хэрэг гарсан улсын харьяаллаас үл хамааран хохирогчдод нөхөн олговор олгох

үндэсний тогтолцоог үр дүнтэй бүрдүүлэхийг Европын бүх улс оронд зөвлөсөн байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах талаар хүсэлт, гомдол гаргах үйл явц нь ил тод байхын зэрэгцээ хохирогчид санхүүгийн болон захиргааны хүнд суртал, дарамт учруулахгүй байх, нөхөн олговор авах эрх үүссэн тохиолдолд энэ тухай шийдвэрийг хохирогчдод шуурхай хүргэх ёстой гэж заажээ.

1.3.4 Нөхөн олговор авах эрх¹²

Европын Холбооны улс орнууд гэмт хэргийн нөхөн олговор олгох чиглэлээр өөр өөрийн зохицуулалт, тогтолцоотой. Зарим улсын тогтолцоо нь санаатай, хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, хор уршгийг нөхөн сэргээх зэргээр хязгаарлагддаг бол зарим улсын нөхөн олговрын тогтолцоо нь гэмт хэргийн улмаас алдагдсан орлого, сэтгэл санааны зовуурь шаналал, бусад нэмэлт зардлыг хамааруулдаг.

Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж дууссаны дараа тухайн хэргийн хохирогч нөхөн төлбөр авахын тулд тухайн хэргийг мөрдөн шалгасан байгууллагаас нотломж, тодорхойлолт авах шаардлагатай байдаг. Тиймээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нөхөн төлбөр олгох процесс, өргөдлөө хэрхэн гаргах, нөхөн олговор авах хүсэлт гаргахад бүрдүүлэх үндсэн шаардлагыг тэдэнд ойлгомжтой хэл, хэлбэрээр мэдээлж, тайлбарлах үүргийг хууль сахиулах байгууллага, шүүх хүлээдэг байна.

1.3.5 Нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах эрх¹³

Нөхөн сэргээх үйлчилгээ нь сэргээн засах, зөвлөгөө өгөх гэх мэт олон төрлийн үйлчилгээг хамардаг. Тус үйлчилгээг эрүүгийн процесс ажиллагаатай зэрэгцүүлэн эсвэл тухайн ажиллагаа

¹² Victim Support Europe, The Criminal Justice Programme of the European Union. Handbook for Implementation of Legislation and Best Practice for Victims of Crime in Europe. (2013) <https://bit.ly/3DDcdm8>

¹³ Мөн тэнд

дууссаны дараа үзүүлж болно. Нөхөн сэргээх үйлчилгээ нь хохирогчдод зайлшгүй үйлчилгээ шаардлагатай гэсэн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэнэ. Энэ нь хохирогчид гэмт хэргийн улмаас үүссэн хор уршиг, стресс, сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэдэг байна. Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн сэргээхийн тулд олон янзын үйлчилгээний хувилбарууд байх ба нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдахын тулд тодорхой аргачлалын дагуу үйлчилгээнд хамрагдах шаардлагатай эсэх, ямар үйлчилгээ тухайн хохирогчид нэн тэргүүнд шаардлагатай болохыг тогтоодог.

Эрүүгийн эрх зүйн хүрээнд болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хохирогчийг хамгаалах талаарх зөвлөмж нь хохирогчийн шүүхэд итгэх итгэл үнэмшлийг бэхжүүлэхээс гадна түүнийг гэрчийн байр суурьтайгаар шүүх ажиллагаанд оролцоход аюулгүй байдлыг хангахад чиглэдэг. Европын холбооны гишүүн орнуудад зориулсан “Гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, сайн туршлага” гарын авлагад гэмт хэргийн хохирогчид учрах бие махбод, сэтгэл санаа, эд хөрөнгө болон нийгэмд учрах хохиролд анхаарлаа хандуулж, энэ талаар хамгаалах бүх төрлийн арга хэмжээ авах аргачлал, зааврыг тусгасан. Энэ хүрээнд нөхөн сэргээх үйлчилгээг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд авах талаар хуульчлах, хэрэгжүүлэх арга замуудыг тодорхой зааж өгчээ. Дээрх гарын авлагад өгсөн зөвлөмжөөс үзвэл нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ хохирогчийн хүсэл сонирхол, зөвшөөрлийг нэн тэргүүнд харгалзан үзэх ёстой гэжээ. Дээрх гарын авлагад дурдсан аргачлалыг нэгтгэн үзвэл дараах алхмыг зөвлөжээ. Үүнд:

- Гэрч, хохирогчийг хамгаалах төрийн бодлогыг боловсруулах;
- Гэрч, хохирогчийг хамгаалах үндсэн зарчмыг боловсруулах;
- Холбогдох хууль тогтоомж гаргах;
- Шүүх ажиллагааг шуурхай, шударга явуулах чадамжтай байхаас гадна оролцогчдын аюулгүй байдлыг хангах болон эрх, эрх чөлөөг нь хамгаалах чадамжтай шүүхийг бүрдүүлэх;
- Хохирогчтой харьцах чиглэлээр шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч

- болон оролцогч байгууллагын ажилтны чадварыг сайжруулах, сургалт явуулах;
- Хууль сахиулах байгууллагын албан тушаалтны зүгээс гэрч, хохирогчтой харьцах дүрэм боловсруулж мөрдүүлэх;
 - Хохирогчдод туслалцаа үзүүлэх албыг бэхжүүлэх;
 - Гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэх хангалттай хөрөнгийг зарцуулдаг механизмыг бий болгох;
 - Зуучлал болон нөхөн олговрын механизмыг бүрдүүлэх, тусгай зориулалтын сан байгуулах, бэхжүүлэх;
 - Тодорхой гэмт хэргийн төрлөөс шалтгаалан гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах. Тухайлбал, зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, терроризмын гэмт хэргийн хохирогчийн асуудал;
 - Хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлыг онцгой анхаарах;
 - Гэмт хэрэгтэй холбоотой аливаа ЭХХША, бусад ажиллагааны явцад болон дараа нь гүтгэлэг, айлган сүрдүүлэх байдлаас хохирогчийг хамгаалах арга хэмжээг боловсруулах;
 - Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын үүднээс шүүх хуралдааныг хаалттай явуулах боломж бүрдүүлэх;
 - Шууд видео дүрсээр, эсхүл видео хальсанд бичсэн гэрчийн мэдүүлгийг ашиглах;
 - Гэрч, хохирогчийн оршин суух газрыг өөрчлөх замаар аюулгүй байдлыг хангах;
 - Төр буюу түүний эрх бүхий байгууллагаас гэмт хэргийн хохирогчийн нөхөн сэргээх үйлчилгээ, хамгаалалтын хүртээмжтэй байдлыг хангах;
 - Шаардлагатай мэдээллээр хангагдах эрхээр хангах. Тухайлбал, хохирогчийн авч болох эрх зүйн болон бусад туслалцаа, хохирлыг барагдуулах боломж (төрөөс болон гэм буруутай этгээдээс гаргуулах)-ийн талаарх мэдээлэл;
 - Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн эрх ашигт хамааралтай шийдвэрийн талаар мэдээллээр хангагдах, аюулгүй байдлаа хамгаалуулах техникийн боломжийг бүрдүүлэх;

- Нөхөн олговор, нийгмийн халамжид хамруулах;
- Хохирогчоос мэдүүлэг авахад түүний хувийн байдал, нэр хүнд, эрхийг хүндэтгэдэг байх;
- Хохирогчийн хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэсний дараа гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх эсэхийг шийдвэрлэдэг байх;
- Хохирогчийн хувийн амьдрал, нэр хүнд хөндөгдөх аливаа баримт, мэдээллийг тараахаас хамгаалагдсан байх;
- Гэмт этгээдийн зүгээс хохирогчийг айлган сүрдүүлэх, аюул заналаас хамгаалах¹⁴.

1.3.6 Нөхөн сэргээх үйлчилгээний стандарт¹⁵

Нөхөн сэргээх үйлчилгээний талаар Европын холбооны стандартыг судлан үзвэл дараах агуулгатай байна. Үүнд:

Хүснэгт 1.1. Европын холбооны нөхөн сэргээх үйлчилгээний стандарт

Хохирогчийг мэдээллээр хангах, зөвшөөрөл авах	Гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нөхөн сэргээх үйлчилгээний саналыг тусгай мэргэжилтэн гаргаж, тодорхойлох ёстой. Хохирогчид хараат бусаар дэмжлэг, зөвлөгөө үзүүлэх боломжтой үйлчилгээний газруудын талаар мэдээлэл өгөх, хохирогчийн зөвшөөрлийн үндсэн дээр үйлчилгээ үзүүлэх;
Хохирогч төвтэй арга барил	Нөхөн сэргээх үйлчилгээний зорилго нь хохирогчийн эрх, ашиг сонирхол байх ёстой. Гэмт хэргийн хохирогчид чиглэсэн сэргээн засах олон арга хэмжээ нь хохирогчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хохирогчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх шаардлагатай.

¹⁴ United Nations. Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power. (1985) <https://www.ohchr.org/en/professionalinterest/pages/victimsofcrimeandabuseofpower.aspx>

¹⁵ Victim Support Europe, The Criminal Justice Programme of the European Union. Handbook for Implementation of Legislation and Best Practice for Victims of Crime in Europe. (2013) <https://bit.ly/3yEs1BK>

Гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрөх	Гэмт этгээдэд гэмт хэрэг (нотлох баримтаар тогтоогдсон) үйлдсэнээ хүлээн зөвшөөрч, тухайн гэмт хэргийн хохирлоо барагдуулах, нөхөн сэргээхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжийг олгох ёстой.
Дэмжлэг ба төлөөлөл	Хохирогчид чиглэсэн үйлчилгээг олон хэлбэрээр үзүүлэхдээ гэр бүлийн гишүүд, хууль ёсны төлөөлөгчийн дэмжлэг туслалцааг авах, хууль ёсны төлөөлөгчийн саналыг харгалзан үзэх;
Мэргэшсэн мэргэжилтнүүд	Нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлж буй хүн хохирогчдын онцгой хэрэгцээг харгалзан зөрчилдөөнийг шийдвэрлэх талаар бүрэн бэлтгэгдсэн байх ёстой. Гэмт хэргийн хохирогчтой ажиллах туршлагатай, нөхөн сэргээх арга хэмжээний үр дүнд хувийн ашиг сонирхолгүй, бие даасан шинжээчид хохирогчид мэдлэг олгох сургалтыг явуулдаг.
Процессын сонголт	Гэмт хэрэгтэнтэй уулзахгүй байхыг илүүд үздэг хохирогчдод шууд бусаар зуучлах эсвэл өөр тохиромжтой арга хэмжээг сонгон хэрэгжүүлнэ.
Нууцлал	Нөхөн сэргээх ажиллагааны явцад цугларсан мэдээлэл нь бүх оролцогчид зөвшөөрснөөс бусад тохиолдолд нууц байна.
Сайн дурын гэрээ	Талуудын хооронд байгуулсан аливаа тохиролцоо сайн дурын үндсэн дээр явагдана.
Үргэлжлэх хугацаа	Хохирогчид хүлээн авсан мэдээллээ эргэцүүлэн бодох боломжийг олгохын тулд нэгээс олон уулзалт санал болгодог.
Хохирогчийг мэдээлэх	Нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан хохирогчдод гэмт этгээдийн гэрээний гүйцэтгэлийн талаар мэдээлж байх ёстой.

ХОЁР.

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ ТОГТОЛЦОО

Энэ бүлэгт гадаадын зарим орны гэмт хэргийн хохирлыг барагдуулах тогтолцоо, эрх зүйн орчин, ажиллагаа, бүтэц зохион байгуулалт болон түүний давуу болон сул талыг харьцуулан судлав. Өмнө нь хийгдсэн судалгааны хүрээнд гарсан санал, зөвлөмжид “Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлд нийцүүлэн гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоох, үнэлэх, нөхөн барагдуулах суурь тогтолцоо бүрдүүлэх шаардлага”-ыг дурдсан билээ.¹⁶ Гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцооны эрх зүйн харьцуулалтыг Үндсэн хууль болон бусад хуулийн зохицуулалт, тусгай хууль, сан, бусад онцлог гэх дарааллаар дэлгэрүүлэн авч үзье.

2.1. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ БАРАГДУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ


Дэлхийн ихэнх улс орон өөрийн Үндсэн хуульдаа иргэнийхээ хөндөгдсөн эрх ашиг сонирхлыг хамгаалах, нөхөн сэргээх суурь зохицуулалтыг оруулсан байдаг бөгөөд энэ нь хүний эрхийг хамгаалах суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Судалгааны энэ хэсэгт ХБНГУ, БНСУ гэсэн хоёр улсыг төлөөлүүлэн авч үзлээ. Ардчилсан тогтолцоотой гадаадын дийлэнх улс орны хувьд эрх ашиг нь хөндөгдсөн, гэмт хэргийн хохирогч болсон иргэнд тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх, эрх ашгийг хамгаалах ерөнхий заалтыг Үндсэн хуульдаа тусгадаг.

¹⁶ Нээлттэй Нийгэм Форум, Монголын Криминологичдын холбоо. Хохирлын үндэсний тогтолцоо. Монгол Улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал. Цуврал судалгаа №1. 91 дэх тал

2.1.1 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцоонд үйлчлэх эрх зүйн орчныг судлан үзэхэд суурь зарчим нь Үндсэн хуульд тусгалаа олсон¹⁷ ба голлох харилцааг Эрүүгийн хууль, Эрүүгийн процессын хууль, Иргэний хууль, Нийгмийн эрүүл мэнд, халамжийн тухай кодификаци, Хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хууль зэрэг хэд хэдэн хуулиар зохицуулсан байна. Холбогдох хууль тогтоомжийг системчлэн харууллаа.

График 2.1. ХБНГУ-ын хохирогчийг хамгаалах эрх зүйн тогтолцоо



Хүний зөрчигдсөн эрхийг сэргээх асуудал нь эрх зүйн харилцаанд шууд нөлөөтэй учир ХБНГУ-ын Үндсэн хуулиар гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцооны суурийг тусгасан байдаг. Тухайлбал, Холбооны Үндсэн Хуулийн Шүүх “Үндсэн хууль нь хохирогчдын үндсэн эрхийг хамгаалах, сурталчлах, тэдний эрх ашгийг шударга ёсыг хамгаалах тогтолцооны бүхий л шатанд хамгаалах, бататгах үүргийг төрийн байгууллагууд хүлээнэ” хэмээн тусгажээ.¹⁸

¹⁷ Fact sheet: Germany. <https://bit.ly/3DBXOqo>

¹⁸ Federal Ministry of Justice. Basic Law for the Federal Republic of Germany. <https://bit.ly/3t3iVwS>

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд заасан нийгэм төрийн байгууламжийн зарчимд үндэслэн төр нь гэмт хэргийн улмаас хөдөлмөрийн чадвар алдсан, тусламж, асаргаа, сувилгаа шаардагдах болсон иргэнд туслах үүрэг хүлээдэг. Учир нь төрөөс иргэдийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

2.1.2 Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын хувьд 1987 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр гэмт хэргийн улмаас хохирсон иргэний эрхийг хамгаалах, нөхөн сэргээх үүргийг төр хариуцахаар болсон.¹⁹ Тухайн заалтыг нэмэлтээр оруулах болсон шалтгаан нь “...иргэнд чиглэсэн үндэсний хамгаалалт болон дэмжлэгийн тогтолцоог сайжруулах шаардлагатай ба нийгмийн бүтэц, төрийн хамгаалалт, тусламж учир дутагдалтай байна” гэж үзжээ.²⁰

БНСУ-ын (1987 оны 10-р сарын 29-ний өдөр шинэчлэн найруулсан) Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт хохирогчийн шүүхэд мэдүүлэг өгөх эрх, мөн 30 дугаар зүйлд хохирогч тусламж үйлчилгээ авах эрх үндсэн эрх болохыг тус тус баталгаажуулсан. Үүнд гэмт хэргийн улмаас биечлэн гэмтсэн хүн хуульд заасны дагуу төрөөс тусламж авч болно. Энэ мэтчилэн гэмт хэргийн хохирогчийн эрхийг НҮБ-аас 1985 оны 11-р сарын 29-ний өдөр баталсан Гэмт хэрэг, эрх мэдлээ хэтрүүлэн ашигласны төлөө хохирогчдын шударга ёсны үндсэн зарчмуудын тунхаглалд нийцүүлж Үндсэн хуульдаа тусгасан.

Энэ хүрээнд тус улс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг БНСУ-ын Их Хурлаар хэлэлцүүлж 2007 оны 6 дугаар

¹⁹ Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хууль. (1987) https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1

²⁰ Korea Certified Valuation Analyst (KCVA), Legal Service and Victim Support Division, Ministry of Justice. Гэмт хэргийн хохирогчийн гарын авлага (A guide for Crime Victims) <https://www.korea.kr/common/download.do?tblKey=EDN&fileId=181614>

сарын 1-ний өдөр баталжээ. Уг хууль нь 2008 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэлт нь хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг дээдлэн, хууль дээдлэх ёс, хуульчийн ёс зүйг илүүд үзэж хуулийн байгууллагыг үйл ажиллагаа болон эрүүгийн хэргийн нотлох баримттай холбоотой асуудал зэргийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын тэгш эрхэд нийцсэн байхаар зорьжээ. Улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй болгох тал дээр анхаарч гэмт хэрэгтэн, хохирогч хоёр талын хувь хүний эрхийг хүлээн зөвшөөрч хүнлэг аргаар шалган шийдвэрлэх системийг бүрдүүлэхэд илүү анхаарсан байдаг.

2.2. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх тогтолцоог ХБНГУ, Польш, Унгар, Эстони, Япон, Солонгос, Канад, ОХУ-ын хууль тогтоомжийн хүрээнд гэмт хэргийн хохирол, хор уршгийг төрөөс нөхөн төлүүлэх, тодорхой тусламж үйлчилгээ үзүүлэх асуудлыг судалж, тэдгээрийн онцлог, ялгааг гаргахыг эрмэлзэв.

2.2.1 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Тус улс нь 1971 онд Хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хууль “Gesetz über die Entschdigung für Strafverfolgungsmaßnahmen (StrEG)”-ийг батлан хэрэгжүүлж байна. Энэ хуулиар шүүхийн өмнөх шатны хохирлыг барагдуулах асуудлыг тусгайлан хуульчлан зохицуулсан. Уг хуулийн 1-р зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас хохирол учирсан этгээд нь тухайн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсвэл ял оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгосон зэрэг бусад байдлаар цагаатгасан тохиолдолд төрийн сангаас хохирол шаардах эрхтэй” гэж хуульчилжээ.²¹

²¹ Gesetz über die Entschdigung für Strafverfolgungsmaßnahmen (StrEG) <https://bit.ly/3Dz3x06>

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45-р бүлэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах” тухай заасан байдаг. Энэхүү шүүхийн өмнөх шатны хохирол барагдуулах тухай заалт нь “шүүгч, прокурор, мөрдөгч” гэж тухайлсан субъектийг заасан байна. Харин ХБНГУ-ын зохицуулалтаас үзвэл, хохирол шаардах эрхийн урьдчилсан нөхцөлд “хууль бус” болон “шүүгч, прокурор, мөрдөгч” гэх нэр томъёог хэрэглэлгүйгээр “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх” гэж томъёолж буй нь шүүхийн өмнөх шатны хохирол барагдуулах тогтолцоог ерөнхийлөн хуульчилж, энгийн ойлгомжтой байдлаар зохицуулжээ.

ХБНГУ-ын хууль тогтоомжид “хохирогч” буюу “victim” гэсэн үгийн хууль ёсны тодорхойлолт байдаггүй. Энэ нэр томъёог ихэвчлэн “co-plaintiff” or “injured party” гэж тодорхойлдог²². “Хохирогч” (victim) гэдэг үгийг шууд утгаар нь ашигладаг хууль бол “Victim Compensation Act” буюу “Хохирогчийн нөхөн төлбөрийн тухай хууль” юм.²³ Энэ нь хохирогчдод төрөөс олгох нөхөн олговрыг зохицуулдаг бөгөөд гэмт хэргийг илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж тогтоож чадаагүй тохиолдолд энэхүү хуулиар нөхөн олговрыг олгодог. Гэмт хэргийн улмаас шууд бус буюу дам байдлаар хохирсон хохирогчдод зориулсан тусгайлсан зохицуулалт байдаггүй.²⁴

Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хууль (Opferentschadigungsgesets (OEG)) нь 1976 онд батлагдсан²⁵ ба тус

²² Fact sheet: Germany. <https://bit.ly/3DCLt5h>

²³ Act on compensation to victims of violent crime, (Crime Victims Compensation Act – OEG) <https://bit.ly/3jxavuy>

²⁴ Fact sheet: Germany. <https://bit.ly/3mRsTAY>

²⁵ ДЫNKEL, F. (1985). Victim Compensation and Offender Restitution in the Federal Republic of Germany-A Western-European Comparative Perspective. *International Journal of Comparative and Applied Criminal Justice*, 9(1-2), 29-39. <https://doi.org/10.1080/01924036.1985.9688805>

хуулиар ХБНГУ-ын нутаг дэвсгэрт санаатай үйлдсэн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болж, улмаар эрүүл мэндээрээ хохирсон хүн нөхөн төлбөр авах хүсэлт гаргах эрхтэй. Хүчирхийллийн гэмт хэргийн улмаас нас барсан хүмүүсийн хамаарал бүхий хүмүүсийн хувьд мөн адил хамаарна. Тодорхой нөхцөлд гадаадын иргэд хохирлын нөхөн төлбөр авах эрхтэй. Хуулийн зорилго нь хүчирхийллийн улмаас учирсан эрүүл мэнд, эдийн засгийн үр дагаврыг нөхөх явдал юм.²⁶ Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн хохирогчдын нөхөн олговрын тухай хуулийг хэрэгжүүлэхийн тулд нэхэмжлэгч хүчирхийллийн үйл ажиллагааны объект байсан бөгөөд эдгээр үйлдлийн үр дагаврыг амссан байх ёстой. Гэмт хэргийн хохирогч эсвэл хохирогч нас барсан тохиолдолд түүний гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн хуулийн дагуу нөхөн төлбөр авах эрхтэй.

Гэмт хэргийн хохирогчдын нөхөн төлбөрийн тухай хуульд хүчирхийллийн үйлдлийг хүний эсрэг санаатайгаар, хууль бусаар хүчирхийлэл үйлдсэн халдлага гэж тодорхойлсон (санаатайгаар биед гэмтэл учруулах, хүчиндэх, бэлгийн хүчирхийлэл гэх мэт). Гэмт хэргийн хохирогч эрүүл мэндэд учирсан хохирол бүрээр нөхөн төлбөр шаардах эрхтэй болдог. Эрүүл мэндтэй холбоотой асуудлууд нь бие махбодын болон сэтгэлзүйн асуудлыг агуулдаг бөгөөд тэдгээр нь түр зуурын болон байнгын байж болно.

Нөхөн олговрын хамрах хүрээг Холбооны Дэмжлэгийн тухай (Federal Support Act) хуулиар тодорхойлсон бөгөөд эмчилгээний зардал болон хохирогчдын тэтгэвэр, асрах тэтгэмж, яаралтай тусламж, амьжиргааны нэмэлт тэтгэмж, орон сууцны тэтгэмж гэх мэт нийгмийн халамжийн тэтгэмжийг хамарна. Нэмж дурдахад, тодорхой нөхцөлд хохирогч тохиолдол бүрд нэмэлт тэтгэмж авах эрхтэй байж болно. Эдгээрийг хувьд чиглэсэн тусламж үйлчилгээ, биет хандив, мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгоно.

²⁶ ODABS. Benefits via the Crime Victims Compensation Act. <https://bit.ly/3t3f9Uh>

ХБНГУ-ын шүүхээс өмнөх шатны хохирлын тогтолцооны бас нэг онцлог нь хохирогчдыг нөхөн сэргээх, тэднийг хохирлоо барагдуулан авахад зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг байгууллагууд давхар ажилладаг явдал юм. Тухайлбал, WEISSER RING бол Герман дахь хохирогчдод туслах үндэсний хэмжээний байгууллага²⁷ бөгөөд тэд гэмт хэргийн хохирогчдод үнэ төлбөргүй тусламж үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлдэг.

“WEISSER RING”-ИЙН ЗОРИЛГО НЬ:

- Гэмт хэргийн хохирогч болон тэдний гэр бүлд яаралтай тусламж үзүүлэх;
- Хохирсон хүмүүст туслалцаа үзүүлэхдээ хууль тогтоомжийн дагуу нийгэмд амьдрахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх, олон нийтийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих;
- Нөхөн төлбөр, гэмт этгээд-хохирогчийг эвлэрүүлэн зуучлахад туслалцаа үзүүлэх, дэмжих.

Энэхүү байгууллага нь хохирогчдыг нийгэмшүүлэх, нөхөн сэргээх чиг үүрэгтэй ажилладаг бөгөөд улсын санхүүжилтээс хараат бус нийтийн эрх зүйн статустай хуулийн этгээд болохын хувьд, гэмт хэргийн хохирогчдод туслах үүрэг хүлээдэг. WEISSER RING-ээс санал болгож буй тусламж нь үнэ төлбөргүй бөгөөд хохирогчдод туслах мэргэжилтнүүд хувийн ашиг сонирхлын төлөө бус, сайн дурын үндсэн дээр ажилладаг. Энэхүү байгууллага нь хохирогчдын айдас, санаа зовнилыг нухацтай авч үзэж, тэднийг сонсож, зөвлөгөө өгдөг, хүнд хэцүү үед нь хамт байдаг байна.

Тус байгууллага нь эрүүгийн гэмт хэргийн нотлох баримт хангалттай бүрдсэн гэж үзвэл өмнө нь гэмт хэрэг үйлдсэн, ял шийтгүүлсэн эсэхээс үл хамааран гэмт хэргийн бүх хохирогч,

²⁷ <https://weisser-ring.de/english>

тэдний ойр дотнын хүмүүс, болон гэрчид тусламж үзүүлдэг. Энэхүү байгууллагын хохирогчдод туслах ажилтнуудын олон төрлийн ур чадвар, туршлага, нөхөн сэргээх үйлчилгээний хөтөлбөрийн үргэлжлэх цаг хугацааны уян хатан байдал нь хохирогчийг үр дүнтэй нөхөн сэргээх боломжийг олгодог.

Хохирогчдын эрхийг сайжруулахын төлөө төрийн бус байгууллагууд тэмцсэний үр дүнд дээрх байгууллагыг байгуулж, Германы Холбооны Зөвлөл 2019 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Нийгмийн ажил үйлчилгээний тухай хуулийг (Social Code Book) баталсан.²⁸ Түүнчлэн ХБНГУ-д гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхтэй холбоотой харилцааны эрх зүйн үндэс нь Нийгмийн эрүүл мэнд, халамжийн тухай кодификацийн 14 дэх боть/хуульд тусгагдсан байх бөгөөд нарийвчилсан харилцааг Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох тухай хуулиар зохицуулдаг. Гаднын иргэдийн хувьд ХБНГУ-д сүүлийн 3 жил буюу түүнээс дээш хугацаагаар хууль ёсны дагуу оршин суусан бол хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд тус хууль үйлчилнэ.

Гэмт хэрэгтэн-хохирогчийг эвлэрүүлэн зуучлах тогтолцоог 1990 онд Эрүүгийн процессын хуулийн хүрээнд Täter-Opfer-Ausgleich/Victim-Offender Mediation, товчилсон байдлаар ТОА нэртэйгээр хуульчилсан байдаг. Энэ нь эрүүгийн процесс ажиллагааны аль ч үе шатанд хийгдэж болох бөгөөд хохирогчийн хохирлыг эв зүйгээр барагдуулах, гэмт хэрэгтнийг яллахаас аль болох татгалзах, шүүхийн зардлыг хэмнэх боломжийг олгодог давуу талтай.²⁹

ХБНГУ-ын эрүүгийн процессын хуулиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд хохирогчийн хохирлыг барагдуулах боломжийг харгалзан үзэх үүргийг прокурор, шүүхэд хуулиар үүрэг болгосон. Өөрөөр хэлбэл, Гэмт хэрэгтэн хохирогчийг эвлэрүүлэх тухай (ТОА) хуулийг хялбаршуулан хэрэглэх зорилгоор

²⁸ <https://weisser-ring.de/english>

²⁹ § 45 section 3 of the Act on Juvenile Courts, JGG – see above IV.4.)

1999 оны Эрүүгийн процессын хуулийн §155a, §155b (StPO) дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулсан.³⁰

155a зүйл 31, Хохирогч – гэмт хэрэгтнийг эвлэрүүлэн зуучлах (Victim – offender mediation)

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд прокурор, шүүх нь яллагдагч, хохирогчийг эвлэрүүлэн зуучлах боломжтой эсэхийг шалгах ёстой. Зохимжтой гэж үзсэн тохиолдолд эвлэрүүлэн зуучлахаар тохиролцож болно. Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг эвлэрүүлэн зуучлахыг хориглоно.

Энэ нь гэмт хэрэгтэн, хохирогч хоёр шүүхийн өмнөх процессын аль ч шатанд тохиролцоонд хүрэх боломжийг хангадаг бөгөөд прокурорын байгууллага, шүүхийн бүрэн эрхийн асуудал юм.³² Мөн эвлэрүүлэн зуучлах аргаар хохирогчийн хохирлыг барагдуулах хүсэлтийг гэмт этгээд, хохирогч эсвэл түүний өмгөөлөгчийн зүгээс гаргаж болохоор хуульчилсан.³³

ТОА-ийн үйл ажиллагааны урьдчилсан нөхцөл бол хохирогч болон яллагдагчийн аль алины тохиролцоонд хүрэх хүсэл зориг юм. Гэмт хэрэг үйлдсэн этгээд үйлдсэн хэргээ хүлээн зөвшөөрсөн бол хохирогчийг эвлэрүүлэн зуучлах боломжтой.³⁴ Хэрэв тухайн нөхцөл хангагдсан бол хохирогч-гэмт хэрэгтнүүдийг эвлэрүүлэн зуучлах ажлыг ихэвчлэн “хараат бус байгууллага” (balancing body) хариуцан хэрэгжүүлдэг.³⁵ Тус алба нь хохирлын нөхөн төлбөрийн үр дүнгийн талаар прокурор, шүүхэд мэдэгдэх үүрэгтэй. Энэ байгууллага нь тухайн хэрэг хууль зүйн үндэслэлтэй явагдаж буй эсэхийг хянах бөгөөд талууд хэлэлцээрт оролцож буй байдлыг хянах, эдгээр хэлэлцүүлгийг удирдан зохион байгуулах, үр дүнг

³⁰ Code of Criminal Procedure, StPO <https://bit.ly/3yJ2xTP>

³¹Section 155a, Code of Criminal Procedure, StPO <https://bit.ly/3BrG13q>

³² Code of Criminal Procedure, StPO <https://bit.ly/3yxxx97>

³³ Code of Criminal Procedure, StPO <https://bit.ly/2V6d2CM>

³⁴ Weisser-ring. <https://bit.ly/3zzhR6B>

³⁵ Jehle, J. M. (2019). Criminal justice in Germany: facts and figures. Forum Verlag Godesberg GmbH.

бүртгэх, нөхөн олговрыг хэрхэн барагдуулсан тухай прокурорын байгууллага, шүүхэд мэдээлэх үүрэгтэй. Эвлэрүүлэн зуучлалын асуудлыг Гэмт хэрэгтэн-хохилогчийн эвлэрүүлэн зуучлах тухай хуулиар нарийвчлан зохицуулсан.³⁶ Шийдвэрлэгдсэн гэмт хэргийн бараг тал хувь буюу 44 хувь нь зуучлагчийн оролцоотойгоор хийгддэг бол 15 хувь нь эвлэрүүлэн зуучлуулахаас татгалздаг байна.³⁷

2.2.2 Бүгд Найрамдах Польш Улс

БНПУ-ын “Тодорхой төрлийн зарим санаатай гэмт хэргийн хохирогчдод төрөөс нөхөн төлбөр олгох тухай хууль” 2005 оны 7-р сард батлагдсан (Pz.U. 169, зүйл. 1415) нь Европын Холбооны Зөвлөлийн 2004 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн гэмт хэргийн хохирогчдын нөхөн төлбөртэй холбоотой удирдамжийг хэрэгжүүлсний үр дүн гэж үздэг. 2009 оны 6 дугаар сарын 12-нд энэхүү актад оруулсан нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсон³⁸ нь Польшийн Сэтгэл Судлалын Холбооны дэргэдэх Эрүүл мэндийн сэтгэл судлалын хүрээлэнгийн үйл ажиллагаа сайжрахад том хувь нэмэр болсон.³⁹

Уг хуульд заасан тохиолдолд хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн гаргасан зардлыг төр хариуцна. Гэхдээ эдгээр зардлыг өөр эх үүсвэрээс санхүүжүүлээгүй байх нөхцөлтэй. Гэмт этгээд шүүхийн шийдвэрээр тогтоосон хохирлоо төлөөгүй, засаж залруулаагүй эсхүл хохирогчийн эмчилгээ, нөхөн сэргээлтэд тогтоосон зардлаас илүү зардал шаардлагатай болсон тохиолдолд хохирогч нөхөн олговор авах хүсэлт гаргаж болно.

³⁶ Jehle, J. M. (2019). Criminal justice in Germany: facts and figures. Forum Verlag Godesberg GmbH

³⁷ Jehle, J. M. (2019). Criminal justice in Germany: facts and figures. Forum Verlag Godesberg GmbH

³⁸ “Польшийн Хуулийн сэтгүүл”, 79-р зүйл, 2009

³⁹ Польшийн Сэтгэл Судлалын Холбооны дэргэдэх Эрүүл мэндийн сэтгэл судлалын хүрээлэн

Хохирсон талын алдагдсан орлого, амьжиргааны бусад төлбөр, эмчилгээ, нөхөн сэргээх зардал, оршуулгын зардлыг гэмт хэрэг үйлдсэн этгээд, даатгуулагч, нийгмийн халамжаас нөхөж барагдуулж чадахгүй тохиолдолд улсын төсвөөс түр төлсөн тэтгэмжийг нөхөн олговорт хамруулдаг хэдий ч энэхүү төрийн нөхөн олговор нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирол барагдуулах үүргээс чөлөөлдөггүй.

Нөхөн олговор олгох нь гэмт этгээдийн ял шийтгэлийн хэмжээнээс хамаардаггүй. Тухайлбал, эрүүгийн хэрэг үүсэх шатанд эсхүл эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдолд ч гэсэн нөхөн олговрыг өгч болохоор заасан. Түүнчлэн тус хуулиар гэмт хэргийн хохиролтой холбоотой нэр томъёог тогтоож, үүнд үндэслэн нөхөн олговор олгох нөхцөл, хүлээн авагчдын эрх, үүргийг тодорхойлсон.

Мөн БНПУ-ын Төрийн нөхөн төлбөрийн тухай хуульд зааснаар нэмэлт нөхөн төлбөр авах үндэслэл нь дараах байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 156 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 157 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар санаатай гэмт хэргийн улмаас хүчирхийлэлд өртсөн, нас барсан, бие махбодод нь гэмтэл учирч, эрүүл мэндээрээ хохирсон этгээд гэж тодорхойлуулсан хохирогч. (доод тал нь 7 хоногоос дээш хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай гэмтэл учирсан);
- Ойр дотнын хүн, өөрөөр хэлбэл хохирогчийн эхнэр, нөхөр эсвэл гэр бүлийн хамтрагч, гэмт хэрэг үйлдэгдэх үед нас барсан хохирогчоос хамааралтай байсан өргөж авсан, үрчлүүлсэн гэх мэт харилцаатай хүн.

2.2.3 Бүгд Найрамдам Унгар Улс


Тухайн улсад гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо Хууль зүйн яамны бүтцэд ажилладаг. Гэмт хэргийн хохирогчийг Дэмжих үйлчилгээг 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс “Хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх, хохирол нөхөн барагдуулах хууль”-ийн дагуу холбогдох төрийн байгууллага хариуцан ажилуулж байна.

Энэ хуульд заасан хүрээнд хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагууд (жишээлбэл, Fehér Gyűrí Közhaszni Egyesület), Улаан загалмайн нийгэмлэг, Мальтын сайн үйлсийн үйлчилгээ гэх мэт сайн үйлсийн аянууд, энэ чиглэлээр дагнан ажиллаж буй Street Caregivers, IOM гэх зэрэг байгууллага олноор үйл ажиллагаа явуулж байна.

Гэмт хэргийн хохирогчоор тогтоосон даруйд Гэмт хэргийн хохирогчийг дэмжих үйлчилгээний талаар мэдээлэх нь цагдаагийн хуулиар хүлээсэн үүрэгт багтдаг. Уг үйлчилгээ нь зөвлөгөө, мэдээлэл, сэтгэл санааны дэмжлэг, хуулийн туслалцаа, хүнд нөхцөл байдалд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр үйл ажиллагаагаа явуулдаг. Хохирогчийг дэмжих, хохирол нөхөн барагдуулах тухай хуулиар санхүүгийн болон захиргааны дэмжлэг чиглэдэг бөгөөд сэтгэл санааны дэмжлэг хараахан сайн хөгжөөгүй байна.⁴⁰

⁴⁰ Implementing victim-oriented reform of the criminal justice system in the European Union. Hungary. Developments on the implementation of victim assistance mechanisms. https://www.apav.pt/ivor/images/ivor/PDFs/Fact_sheet_hungary.pdf

График 2.2. Унгар Улс дахь хохирогчийг дэмжих үйлчилгээ



Эх сурвалж: *Victims of Crime Implementation Analysis of Rights in Europe. National report of Hungary.* (2019) https://victimsupport.eu/activeapp/wp-content/uploads/2019/08/VOCIARE_National_Report_Hungary_interactive.pdf

2.2.4 Бүгд Найрамдах Эстони Улс

Эстони Улсад Хохирогчдыг дэмжих тухай хууль 2003 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан. Уг хууль нь 2003 онд батлагдсан боловч хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой зохицуулалтууд 2016, 2017 оны нэмэлт өөрчлөлтөөр орсон. Хохирогчдыг дэмжих тухай хууль нь 5 бүлэг 63 зүйлтэй. Энэхүү хууль нь хохирогчийг дэмжих төрийн байгууллага, эвлэрүүлэн зуучлах, эмэгтэйчүүдийг дэмжих төвийн үйлчилгээг зохион байгуулах, хүн худалдаалах гэмт хэрэг, насанд хүрээгүй бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг дэмжих үйлчилгээг зохион байгуулах, энэ хүрээнд

төлсөн сэтгэлзүйн тусламж үйлчилгээний зардлыг нөхөн төлөх, хохирогчдод дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдод төрөөс нөхөн олговор олгох ажлыг зохион байгуулах үндэслэл, журмыг тусгасан.

2.2.5 Япон Улс

Тус улс гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна. Гэмт хэргийн улмаас хохирогчдод учирсан зардал болох эмчилгээний болон сувилахуйн зардал, шилжин суурьших зардал, амьжиргааны зардал гэх мэт зардлыг бүхэлд нь хохирогчид өөрсдөө хариуцдаг байв.⁴¹ Шүүх ажиллагааны хүрээнд тэдний цорын ганц үүрэг бол гэмт хэрэгтнүүдийн ял шийтгэлийг баталгаажуулах “нотлох баримт” гарган өгөх явдал байсан нь учир дутагдалтай байв.

2004 онд Гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийг⁴² хэрэгжүүлснээс хойш Японд гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тогтолцоо, бодлогод томоохон ахиц дэвшил гарчээ. Гэсэн хэдий ч хуулийн үйлчлэлд хамрагдаагүй, хэвийн ажиллаж амьдрахын тулд тэмцэж буй олон хохирогч байсаар байна.

Гэмт хэргийн хохирогчдыг дэмжих дээрх хуулийн зорилго нь гэмт хэрэгт хохирсон хүнд сэтгэцийн тусламж үйлчилгээ үзүүлж, хохирогчийн эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хангахад чиглэдэг. Жил бүр гэмт хэргийн хохирогчдод чиглэсэн хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн баталдаг ба 2021 онд гэхэд хохирогчдод чиглэсэн дунд болон урт хугацааны нөхөн сэргээх хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлжээ.⁴³

⁴¹ Ito Fujie, Ishii-Takiguchi Ryoko. The Current Status and Issues in Crime Victim Support in Japan. (2020.06) http://www.sophia-humans.jp/departments/socialservices_bulletin/pdf/2020_06.pdf

⁴² 犯罪被害者等基本法.Basic Act on Crime Victims. 2004.12.08 <https://bit.ly/2WFX9mK>

⁴³ Ito Fujie, Ishii-Takiguchi Ryoko. The Current Status and Issues in Crime Victim Support in Japan. (2020.06) http://www.sophia-humans.jp/departments/socialservices_bulletin/pdf/2020_06.pdf

Уг хөтөлбөрийг батлах болон хуулийг хэрэгжүүлж гэмт хэргийн гэрч, хохирогчийг нөхөн сэргээхэд дараах зүйлс ач холбогдолтой гэж үзэж эрэмбэлжээ. Үүнд:

- Санхүү, орон сууц, эмнэлгийн тусламж, хөдөлмөр эрхлэлт, боловсрол гэх мэт үйлчилгээний янз бүрийн чиглэлээр олон байгууллагын хамтын ажиллагааг хангах тогтолцоотой байх. Үүний тулд хохирогчдыг дэмжих зөвлөл байгуулан, тогтмол уулзалт зохион байгуулж, байгууллага бүрийн үүргийг тодруулж, баталгаажуулах;
- Орон нутгийн засаг захиргааны хохирогчдод үзүүлэх арга хэмжээний хүрээнд дээр дурдсан олон байгууллагын хамтын ажиллагааны төв байгуулах. Үүнд эрүүл мэнд, халамжийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийг томилж, тусламж үйлчилгээний менежментийг хэрэгжүүлэн, байгууллага бүрийн үйлчилгээ (нийгмийн нөөц)-г уялдуулан хянаж байх ёстой.
- Нөхөн сэргээх хариу арга хэмжээ, төрөл бүрийн зөвлөгөө авах үйлчилгээг нэг дороос авах боломжийг хохирогчдод олгодог нэг цэгийн үйлчилгээ байдлаар хөгжүүлэх.
- Гэмт хэргийн хохирогчдод тулгардаг хүндрэл бэрхшээлийг чирэгдэлгүй, хялбар шийдвэрлэх. Хохирогчид тухайн улсын хаана амьдарч байгаагаас үл хамааран цаг алдалгүй, зохих дэмжлэг авч, амьдралаа сэргээх боломжийг олгодог тогтолцоог бий болгохыг зорьж байна.

2.2.6 Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-д 1990-ээд оноос ашгийн бус байгууллагууд бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Тухайлбал, Бэлгийн хүчирхийллийн эсрэг төв (Korea Sexual Violence Relief Center)⁴⁴ нь 1991 оны 4 дүгээр сарын 13-нд байгуулагдсан бөгөөд бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн

⁴⁴ <https://bit.ly/3gPTWbv>

эрхийг хамгаалах асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулсан. 1992 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр виктимологийн чиглэлээр эрдэм шинжилгээний ажлыг эхлүүлсэн ба Хохирогчдын холбоо (Korean Association of Victimology) байгуулагдсан. Улмаар бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зарим гэмт хэргийн хохирогчдод тусгай арга хэмжээ авах шаардлагатай байгааг нийгэм өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч байна.

БНСУ-ын Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль 2010 онд батлагдаж, 2017 он хүртэл 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Нийт 8 бүлэг 50 зүйлээс бүрдсэн уг хууль нь гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилготой. Төр, орон нутгийн засаг захиргаа нь гэмт хэргийн хохирогчид зөвлөгөө өгөх, эмнэлгийн тусламж үзүүлэх, нөхөн олговрын сан бий болгох, хууль зүйн туслалцаа, ажил эрхлэлтийн туслалцаа, орон байрны дэмжлэг үзүүлэх болон бусад шаардлагатай хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахаар заасан.⁴⁵ Үүнтэй холбоотойгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хохирогчийн эрхийн баталгаа, гэмт хэргийн хохирогчийн мэдээллээр хангагдах эрхийг тус хуулийн 8.2 дугаар зүйлд тусгаж⁴⁶ хувь хүний нууц, бие махбодын аюулгүй байдал болон бусад хамгаалалтыг тусгасан.⁴⁷ Мөн хуулийн 10 дугаар зүйлд хохирогчийг хамгаалах, дэмжихтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг этгээдэд шаардагдах боловсрол, сургалтаар хангахыг төр, нутгийн удирдлагад үүрэг болгосон байна. Тус хуулийн 11 дүгээр зүйлд хохирогчийн нөхцөл байдлын үнэлгээ хийх, шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлэх зэргийг тусгажээ. Мөн хуулийн 15 дугаар зүйлд Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах зөвлөлийн эрх үүрэг, үйл ажиллагааны талаар зохицуулжээ. Уг зөвлөл нь Хууль зүйн сайдын удирдлагад ажиллаж хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах болон гэмт хэргийн

⁴⁵ Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (2010) 7-р зүйл

⁴⁶ Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (2010) 8-р зүйл

⁴⁷ Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (2010) 9-р зүйл

хохилогчийг хамгаалах, дэмжлэг туслалцаа үзүүлэх талаар зөвлөлдөх, шийдвэр гаргах чиг үүрэгтэй.

Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах зөвлөл нь мастер төлөвлөгөө болон хэрэгжилтийн төлөвлөгөө, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих гол бодлогыг боловсруулах, зохицуулах, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, зөвлөлийн даргаас зөвлөлдөх шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын хүрээнд зөвлөлдөнө. Хамгаалах зөвлөл нь зөвлөлийн даргыг оролцуулаад 20-оос дээшгүй гишүүдээс бүрдэнэ. 12 дугаар зүйлд заасны дагуу 5 жил тутамд хохирогчийг хамгаалах, дэмжихэд чиглэсэн мастер төлөвлөгөө гаргадаг. Мастер төлөвлөгөөнд дараах асуудлыг багтаасан байна. Үүнд:

1. Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих бодлогын үндсэн чиглэл, зорилтууд;
2. Гэмт хэргийн хохирогчийн хамгаалалт, дэмжлэгийг сайжруулах, нөхцөл байдлын талаарх санал асуулга, судалгаа, боловсрол;
3. Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих чиглэлийн байгууллагын дэмжлэг болон хяналт;
4. Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжихтэй холбоотой санхүүгийн эх үүсвэр, түүний зарцуулалт;
5. Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжихэд шаардлагатай хэмээн Хууль зүйн сайдын үзсэн бусад асуудал.

Уг хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах зөвлөл хариуцдаг⁴⁸ ба Хууль зүйн сайд, холбогдох төв захиргааны агентлагуудын удирдлага, хот, мужийн захирагч гэсэн дарааллаар хэрэгжүүлдэг байна. Хэрэгжилтийн биелэлтийг хангаж, үнэлэхэд шаардлагатай гэж үзвэл холбогдох төв захиргааны агентлагуудын удирдлага хамтран ажиллана.⁴⁹

⁴⁸ Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (2010) 13-р зүйл

⁴⁹ Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль (2010) 14-р зүйл

Харин төв захиргааны агентлагуудын удирдлага, хотын, мужийн захирагчид шаардлагатай гэж үзвэл холбогдох төв захиргааны агентлагийн удирдлага, нутгийн удирдлага, олон нийтийн байгууллагын удирдлагад хамтран ажиллах хүсэлт тавих боломжтой. Агентлаг, байгууллага, нутгийн удирдлагууд хамтран ажиллах хүсэлт хүлээн авсан тохиолдолд татгалзах шалтгаан үгүй бол хүсэлтийг хангаж ажиллана. Тус хуулийн 4-р бүлэгт гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийн нөхөн олговрыг зохицуулсан.

1. Гэмт хэргийн хохирлын нөхөн олговрыг бүрэн болон хэсэгчлэн авч чадаагүй.
2. Өөрийн болон бусад этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гомдол, мэдүүлэг, гэрчийн мэдүүлэг өгсөн, эд мөрийн баримт гаргаж өгсний улмаас хохирсон бол хохирогч, эсвэл хохирогч нас барсан бол гэр бүлийн гишүүдэд гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нөхөн олговрын сангаас олговор олгоно гэжээ.

Нөхөн олговор олгохгүй тохиолдлыг мөн зааж өгсөн. Үүнд:

1. Хохирогч болон хохирол учруулагч хоорондоо гэр бүлийн дараах харилцаа байгаа тохиолдолд нөхөн олговор төлөгдөхгүй:
 - a. Гэрлэгчид (үүнд хамтран амьдрагч багтана);
 - b. Цусан төрлийн шууд залгамжлагч;
 - c. 4 үе доторх төрөл садан;
 - d. Хамт амьдарч буй төрөл садан.
2. Хохирогчид дараах тохиолдолд олговрыг бүхэлд нь олгохгүй:
 - a. Тухайн гэмт хэрэгт бусдыг хатгасан болон хамжиж үйлдсэн;
 - b. Хэрцгий аргаар хүчирхийлж, заналхийлж, ноцтой доромжилсон болон бусад үйлдлээрээ гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн;
 - c. Тухайн гэмт хэргийг мөрдөн шалгахад саад учруулсан илт хууль бус үйлдэл үйлдсэн;
 - d. Тухайн гэмт хэргийг үл мэдээлсэн, нуун дарагдуулсан шинжтэй үйлдэл гаргасан;

- e. Бүлэглэн болон гэмт зан үйлийн үндсэн дээр гэмт байгууллагад нэгдсэн, гишүүнээр элссэн (Гэмтэл бэртэл авч, хохирогч болсонтой нь уг байгууллагад нэгдсэн үйлдэл холбоогүй тохиолдолд энэ заалт үйлчлэхгүй);
 - f. Уг гэмт үйлдэлд өс хонзонгийн сэдлээр гэм буруутай этгээд, тэдгээрийн төрөл садан, бусад ойр холбоотой этгээдийн амь насанд хохирол учруулсан, биед хүнд гэмтэл учруулсан.
3. Хохирогчид дараах тохиолдолд нөхөн олговрын зарим хэсгийг олгохгүй. Үүнд:
- a. Хохирогчийн хүчирхийлэл, заналхийлэл, доромжлолын улмаас тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн;
 - b. Хохирогчийн хайхрамжгүй, зохисгүй зан байдал гэмт хэрэг гарахад шууд нөлөөлсөн.

Гэмт хэргийн хохирогч хамгааллын сангийн тухай хуулийг 2014 оны 10 дугаар сарын 15-нд шинэчлэн найруулж, 2015 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн, 17 зүйл бүхий уг хуулийн зорилго нь гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих зорилго бүхий гэмт хэргийн хохирогч хамгааллын санг байгуулах, удирдах, үйл ажиллагаа явуулах асуудлыг зохицуулахад оршино. Уг хуулийн 3 дугаар зүйлд тус санг Засгийн газар байгуулахаар заасан.

- 2006 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс Эрх зүйн үйлчилгээ болон хохирогчийг дэмжих хэлтэс байгуулсан нь гэмт хэргийн хохирогчийн асуудлыг зохицуулах болсон;
- 2006 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих суурь төлөвлөгөөг баталсан. Энд гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих үндэсний болон орон нутгийн, иргэний нийгмийн байгууллагуудын ерөнхий төлөвлөгөөг багтаасан. Мөн холбогдох төв захиргааны байгууллагууд, орон нутгийн захиргаа жил бүрийн Суурь төлөвлөгөөг батлан мөрдүүлж ирсэн.⁵⁰

⁵⁰ Korea Certified Valuation Analyst (KCVA), Legal Service and Victim Support Division, Ministry of Justice. Гэмт хэргийн хохирогчийн гарын авлага (A guide for Crime Victims) <https://www.korea.kr/common/download.do?tblKey=EDN&fileId=181620>

Гэмт хэргийн хохирогчдыг дараах байгууллагууд дэмжин ажилладаг. Үүнд:

1. Хууль зүйн яамны Эрх зүйн үйлчилгээ болон хохирогчийг дэмжих хэлтэс
Тус хэлтэс нь гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих асуудлыг хариуцан ажилладаг. Үүнд хохирогчид учирсан хор уршгийг нөхөн төлөхөд дэмжлэг үзүүлэх, хохирогчийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх, хохирогчийн эрхийг хангах, хохирогчийг дэмжих, хамгаалах суурь бодлогууд орно.
2. Прокурорын байгууллага
Прокурорын дээд албаны гэмт хэргийн хохирогчийн эрхийн хэлтэс хохирогчийг дэмжихтэй холбоотой асуудлыг хариуцдаг. Прокурорын бүх алба нь хохирогчийг хамгаалах, хохирогчийг дэмжих асуудал хариуцсан прокурортой.
3. Үндэсний цагдаагийн байгууллага
Үндэсний цагдаагийн байгууллагын Үндсэн эрхийн төв хохирогчийг дэмжих ажлыг хариуцах бөгөөд цагдаагийн товчоо болгон хохирогчийг дэмжих чиглэл бүхий хохирогчийн хамгаалал хариуцсан албан хаагчтай.

Гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд онцгой байдлын туслалцаа, зөвлөгөө, эрх зүйн туслалцаа үзүүлэх, хүч хэрэглэсэн буюу гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалан байршуулах хэлбэрээр тусалдаг.

2.2.7 Канад Улс

Тус улсад гэмт хэргийн хохирогчид чиглэсэн үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт, мөрдөн байцаах, гэрч хохирогчийг хамгаалах ажиллагааны журам муж бүрд мэдэгдэхүйц ялгаатай байгаа ч эдгээр тогтолцоо нь нийтлэг нэг шинж чанартай буюу гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хохирогчид чиглэсэн аюул заналын аливаа хэлбэрийн тухай мэдээлэх зэргийг багтаасан байдаг. Тус улсын хувьд тодорхой төрлийн хүнд гэмт хэргийг эс

тооцвол 1 жилийн дотор (зарим мужид 2 жил) багтаж хохирол барагдуулах хүсэлт гаргах эрхтэй. Гадаадын иргэд мөн нөхөн төлбөр авах хүсэлт гаргах эрхтэй.

Гэмт хэргийн хохирол нэхэмжлэгч нь хүч хэрэглэсэн гэмт хэргийн эсвэл хувь хүний халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, амь хохирогчийн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс байна. Нэхэмжлэгч нь гэмт хэрэг гарсан муж дахь хөтөлбөртэй холбоо барьж хүсэлт, гомдол гаргаж болох бөгөөд өргөдлийг тухайн муж дах хөтөлбөрийн нэгжид хандах эсхүл хүсэлт илгээх ёстой. Гэмт хэргийн хохирол нөхөн төлөх шийдвэрийг ихэвчлэн хүсэлт гаргаснаас хойш 1-5 жилийн дотор шийдвэрлэдэг. Шийдвэр гарсны дараа нөхөн төлбөрийг нэхэмжлэгчид ойролцоогоор 4 долоо хоногийн дотор төлнө. Нөхөн олговрын хэмжээ нь 5,000-25,000 канад долларын хооронд хэлбэлздэг. Нөхөн олговор нь эмнэлгийн, сэтгэцийн эрүүл мэндийн зардал, хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийн цалин хөлс алдагдсан боломж, хохирогчдын асран хамгаалагчдад үзүүлэх дэмжлэг, оршуулгын зардал, хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдын нөхөн сэргээлт, хохирогчийн өмнө нь хийж байсан ажилтай дүйцүүлэх ажлын байраар хангах гэх мэт төрөлтэй. Нас барсан болон эдгэршгүй өвчтэй хүмүүст нөхөн олговрыг шуурхай олгодог. Бүс нутгийн хөтөлбөрийг бүс нутгийн татвар, хураамжаас бүрдүүлсэн орлого, санхүүжүүлдэг.

Хохирогчийн шуурхай хариу арга хэмжээ авах хөтөлбөр (VQRP+) нь Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид шаардлагатай туслалцаа үзүүлэх Засгийн газрын хөтөлбөр юм. Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хувьд ойр дотнын хүний эсрэг үйлдсэн хүчирхийлэл, ноцтой халдлага, бэлгийн хүчирхийлэл, заналхийлэл, аллага, аллага үйлдэхийг завдсан гэх төрөлтэй. Тусламж үйлчилгээ үзүүлэх журмыг тодорхой тогтоосон байдаг ба хөтөлбөрөөс мөнгөн тусламж авахын тулд холбогдох баримтыг бүрдүүлсэн байх ёстой ба шүүх хуралдаанаар хэрэг хянан хэлэлцсэн байхыг шаарддаггүй.

VQRP+ нь дараах зардлыг төлнө.

- Орон байрны болон хувийн аюулгүй байдалтай холбоотой яаралтай зардал, жишээлбэл, дохиолол тавих;
- Зөвлөгөө авах эсвэл богино хугацааны нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах дэмжлэг, аяллын зардал;
- Оршуулгын зардал;

Хэрвээ гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан бол дэмжлэгийн хэмжээ нэмэгдэх боломжтой. VQRP+ нь дараах зүйлийг төлдөггүй. Үүнд:

- Шаардлагатай эмчилгээ хийлгэх
- Гэмт хэргийн улмаас ажиллах боломжгүй болсноос алдагдсан орлого.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх өргөдлийг дараах тохиолдолд гаргана.

- Гэмт хэргийн газрыг цэвэрлэх эсвэл гэрийн орчин дахь аюулгүй байдлаа хангуулахын тулд гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш 45 хоногийн дотор;
- Богино хугацааны зөвлөгөө, уугуул иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш 6 сарын хугацаанд;
- Хүнд гэмтлийн зардлын төлбөрийг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор.

Гэмт хэргийн талаар цагдаад эсвэл хохирогчийг дэмжих олон нийтийн байгууллагад мэдээлэх үед тэд танай орон нутгийн VQRP+ үйлчилгээ хүргэх байгууллагад хандана. Эдгээр байгууллага хохирогчдод хямралын тусламж, лавлагаа үйлчилгээ санал болгодог. Тэд мөн VQRP+ хөтөлбөрт өргөдөл гаргахад тусалдаг байна. VQRP+ нь хүсэлтийг дараах хугацаанд шийдвэрлэнэ.

- Оршуулгын болон яаралтай зардлыг ажлын 3 хоногийн дотор;
- Зөвлөгөө өгөх эсвэл уугуул иргэдийн уламжлалт эмчилгээний зардлыг ажлын 5 хоногийн дотор;
- Хүчирхийллийн улмаас хүнд бэртсэн хүмүүсийн өргөдлийг ажлын 10 хоногийн дотор.

2.2.8 Оросын Холбооны Улс

ОХУ-ын Төрөөс хохирогч, гэрч болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчдыг хамгаалах холбооны хууль 2004 оны 8 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан. Энэ хууль хэрэгжиж эхэлснээр хохирогчдод учирсан гэмт хэргийн хохирлыг нөхөн төлөхөд ахиц гарсан. Уг хуулиар аюулгүй байдлыг хангах ажиллагааг нарийн зохицуулж өгсөн. Тухайлбал, хувийн хамгаалалт, орон байр, эд зүйлийн хамгаалалт, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох, холбоо харилцааны болон дохиоллын системийн хэрэгслүүдийг олгох, утасны дугаар болон автомашины дугаарыг нь өөрчлөх, тодорхой хугацаанд аюулгүй газар байлгах зэрэг орно. Эрүүгийн хүнд болон онц хүнд гэмт хэргийн хувьд дээрхээс гадна амьдрах газрыг нүүлгэн шилжүүлэх, бичиг баримтыг өөрчлөх, гадна төрхийг өөрчлөх (пластик хагалгаа хийх хүртэл) зэрэг ордог байна. Энэ бүх арга хэмжээг холбооны төсөв болон хуульд заасан бусад эх сурвалжаас санхүүжүүлэх бөгөөд ямар ч тохиолдолд хамгаалалтад байгаа хүмүүсээр өөрсдөөр нь санхүүжүүлж болохгүй гэж заажээ.

Хуульд нэг удаагийн болон бусад хэлбэрийн мөнгөн тусламж олгох зэрэг нийгмийн хамгааллын арга хэмжээг хуульчилж өгсөн нь том ахиц болсон. Мөн иргэний болон улсын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэсний улмаас гэмтэл авч хөгжлийн бэрхшээлтэй болсон эсвэл эд хөрөнгөөрөө хохирсон хүмүүсийн хохирлыг нөхөн төлөх тухай асуудлыг тусгасан. Нөхөн төлбөрийн хэмжээг ОХУ-ын ЗГ тогтооно. Ийнхүү тухайн хууль батлагдсанаар хохирогчийг хамгаалах асуудал нэг алхам урагшилсан. Хохирол нөхөн төлөх асуудал нь ихэнхдээ доорх аргаар шийдвэрлэгддэг. Үүнд:

- эд зүйлд нь халдсанаар хохирогчид учирсан материаллаг хохирлыг (үүнд олж болох байсан ашиг орлого ч орно) гэмт этгээдээр нөхөн төлүүлэх;
- материаллаг хохирлыг нийгмийн фонд болон хохирогчийг хамгаалах байгууллагуудад төсөвлөсөн зардлаас нөхөн төлөх;
- материаллаг болон сэтгэл санааны хохирлыг шүүхийн

шийдвэрээр улс нөхөн төлөх (эд материалаар болон бусад хэлбэрээр);

- эрүүл мэнд болон сэтгэл зүйг нь нөхөн сэргээх (гэмтлийг эмчлэх, сэтгэцийн өөрчлөлтийг эмчлэх г.м.);
- хохирогчийн сэтгэл зүй, сэтгэл санааг нөхөн сэргээх, нийгэмд эзэлж байсан байр суурийг нь сэргээх;
- хохирогчдыг гэмт явдлын улмаас давтан хохироохгүйн төлөө хамгаалалтад авах.

ОХУ-ын ЭБШХ-ийн 42, 44-р зүйлд гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигт хүний биед учирсан эрхтэн, эд хөрөнгө, сэтгэл санааны хохирлыг ойлгоно гэж өргөн агуулгаар тодорхойлсон байдаг.

Судалсан улс орнуудын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд гэмт хэргийн хохирлыг тогтоож үнэлэх, нөхөн төлүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрджээ. Судлагдсан орнуудад хэргийг эцэслэн шийдээгүй байхад нөхөн олговор авч болох үндэслэл журамтай байхад эсрэгээр зарим оронд тухайн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараа нөхөн олговор, нөхөн сэргээх үйлчилгээ авах эрх үүсэх ялгаатай зохицуулалтуудтай байна.

2.3. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫН САН

Нээлттэй Нийгэм Форум, Монголын Криминологичдын холбооноос хийсэн “Хохирлын үндэсний тогтолцоо. Монгол Улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал” судалгааны зөвлөмжид “гэмт хэрэг, зөрчлийн торгууль, хүүгийн орлого орон нутгийн төсвийн бус орлогод төвлөрч байгааг өөрчилж, хохирлын сан бий болгох, энэ сангаар дамжуулан гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох тухай зохицуулалт бий болгох”-ыг санал болгосон.⁵¹ Тиймээс энэ хэсэгт нөхөн олговрын сангийн талаар дэлгэрүүлэн авч үзлээ.

⁵¹ Нээлттэй Нийгэм Форум, Монголын Криминологичдын холбоо. Хохирлын үндэсний тогтолцоо. Монгол Улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал. Цуврал судалгаа №1. 91 дэх тал

НҮБ-ын 1985 оны Төр засгийн дураар аашлах явдал болон гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн эрхийг сэргээх тунхаглалд хохирсон иргэдийн хохирлыг барагдуулах үйл ажиллагаанд зарчмын шинжтэй хэрэглэгдэх асуудлуудыг бэхжүүлсэн байна. Уг тунхаглалын 8-р зүйлд зөрчил гаргагч, эсвэл гуравдагч талууд хохирогч, тэдний гэр бүл, асран хамгаалагч харгалзан дэмжигч нарын эрхийг шударгаар сэргээх үүрэгтэй, энэ үүрэгт эд зүйлсийг нь буцаан олгох, учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэмт явдлын улмаас гарсан зардлыг нөхөн төлөх, тусламж дэмжлэг үзүүлэх, эрхийг нь сэргээх зэрэг асуудлууд багтана, 9-р зүйлд Улс орнууд хохирогчийн эрхийг сэргээх явдал нь ял шийтгэлийн нэг хэлбэр гэж үзэн хууль тогтоомждоо оруулах, 12-р зүйлд хэрэв өөр боломж байхгүй бол улс орнууд гэмт явдлын улмаас бие эрхтний хүнд гэмтэл авсан, сэтгэл санаа эрүүл мэндээрээ хүндээр хохирсон иргэдэд болон нас барсан, сэтгэл санаа эрүүл мэндээрээ хөдөлмөрийн чадваргүй болсон хүмүүсийн ар гэрт нь мөнгөн тусламж олгоно, 13-р зүйлд мөн хохирогч нарын хохирлыг барагдуулж байхын тулд үндэсний фондуудыг байгуулах нь зүйтэй гэсэн байна.

Судлагдсан улс орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдсэн яллагдагч, шүүгдэгч гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгаа нөхөн барагдуулах нь нээлттэй боловч, тусгай сан, даатгалаас нөхөн төлбөрийг олгож, дараа нь гэм буруутай этгээдээс нөхөн гаргуулах замаар ихэнхдээ шийдвэрлэж байна. Мөн хохирогчид сэтгэл санааны нөхөн төлбөр гаргуулж, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулж байгаа тохиолдол нь ихэвчлэн хүч хэрэглэсэн, хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, заналхийлэх гэх мэт хүний сэтгэл санаанд хохирол учруулдаг хэргүүдийг хамруулж байна. Харин хулгай, залилан, завших гэх мэт нийтлэг үйлдэгддэг гэмт хэргүүдийн хувьд хохирлыг нөхөн төлбөрийн эсхүл даатгалын сангаас гаргуулж, гэм буруутай этгээдээс эргүүлэн нөхөн төвлөрүүлэх замаар зохицуулжээ. Ингээд улс орнуудын хувьд гэмт хэргийн хохирол барагдуулах, нөхөн төлөх сангийн талаар авч үзье.

Хүснэгт 2.1. Улс орнуудын гэмт хэргийн хохирол барагдуулах, нөхөн төлөх сан

Улс	Санг байгуулсан эрх зүйн зохицуулалт	Тайлбар
ХВНГУ	Хохирогчдын хохирлыг нөхөн барагдуулах тухай хууль (1976 он) ⁵²	Нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд хүнд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тухай заасан байдаг бол Баруун Европын ихэнх орнууд нөхөн олговрын тусгай сангаас нэг удаагийн тэтгэлэг олгодог.
БНПУ	“Гэмт хэргийн хохирогчид туслах сан” “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” 1997 он, 2015 оны нэмэлт, өөрчлөлт “Төрийн нөхөн олговрын тухай хууль” 2005 он ⁵³ “Хохирогчид дэмжлэг үзүүлэх сангийн тухай журам” ХЗЯ, Польш	Польш улсад 2005 оны 7-р сарын 7-ны өдөр Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчдод төрөөс нөхөн олговор олгох тухай хууль (O.J. No. 169, 1.415-р зүйл; одоо Төрийн нөхөн олговрын тухай хууль) батлагдсан. Мөн 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр “Хохирогч ба цагаачдад тусалцаа үзүүлэх сан” байгуулагдсан. Тус улсын Гэмт хэргийн хохирогчдод туслах сан нь үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд гэмт хэргийн хохирогчийг дэмжих 15 төвөөс бүрддэг. Захиргааны нэгж бүрд нэг төв байх бөгөөд хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс зарим төвүүд үйл ажиллагаагаа явуулж буй дүүрэгтээ салбараа байгуулжээ.
Эстони	Хохирогчдод тусламж, дэмжлэг үзүүлэх тухай хууль, 2003 он ⁵⁴	Хохирогчдыг дэмжих тухай хуульд заасны дагуу хохирогчид төлөх нөхөн төлбөрийг төрөөс санхүүжүүлдэг. Үүнд хохирогчийг дэмжих үйлчилгээ, эвлэрүүлэн зуучлах ажлын санхүүжилтийг Эстонийн Үндэсний Нийгмийн Даатгалын сан хариуцахаар заасан. Тус сан нь торгууль, ял шийтгэлийн орлого, улсад төлсөн нөхөн төлбөр, буцаан олголт зэргээс санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлдэг.
Унгар	Гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох, тусламж дэмжлэг үзүүлэх тухай хууль, 2005 он ⁵⁵	Унгар Улсын хувьд бүх тусалцаа дэмжлэгийг төрийн хохирогч дэмжих нийгмийн үйлчилгээний хүрээнд явуулдаг. Үйлчилгээг мэргэжилтнүүд үзүүлэх бөгөөд нөхөн төлбөрийг бүхэлд нь төрөөс хариуцдаг. 2004 онд Европын Зөвлөлийн 2004/80/ЕС тоот зөвлөмж, 2012 оны зөвлөмжийг хэрэгжүүлж тусгайлан хууль баталж, хэрэгжүүлсэн. ⁵⁶

⁵² <https://bit.ly/3kJL6gz>, Act on compensation to victims of violent crime, (Crime Victims Compensation Act – OEG)

⁵³ Assistance to Victims of Crime in Poland selected issuesprovidus.lv/upload_file/Projekti/Kriminalitesibas/Victim support/5. PL.pdf • Assistance to Victims of Crime in Poland – - [PDF Document] (documents.pub)

⁵⁴ <https://www.riigiteataja.ee/en/eli/521122013001/>

⁵⁵ <https://providus.lv/wp-content/uploads/2021/07/4.-HU.pdf> Crime Victim Support and State Compensation Act (Victim Support Act 2005) Hungary

⁵⁶ Victims of Crime Implementation Analysis of Rights in Europe. National report of Hungary.

Хүснэгт 2.1-ийн үргэлжлэл

Улс	Санг байгуулсан эрх зүйн зохицуулалт	Тайлбар
БНСУ	Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль, 2017 он (шинэчилсэн найруулга) Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах сангийн тухай хууль ⁵⁷ 2014 он	Гэмт хэргийн хохирогч хамгааллын сангийн тухай (2014) ⁵⁸ 17 зүйл бүхий хуулийн зорилго нь гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, дэмжих зорилго бүхий гэмт хэргийн хохирогч хамгааллын сан байгуулах, удирдах, үйл ажиллагаа явуулах асуудлыг зохицуулахад оршино. 3 дугаар зүйлд зааснаар тус санг Засгийн газар байгуулна. Санг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. <ul style="list-style-type: none"> Гэмт хэргийн хохирогч хамгааллын сангийн тухай хуулийн (2) хэсэгт тусгасан торгуулийн төлбөр; Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу төлүүлсэн хохирлын нөхөн төлбөр; Засгийн газраас бусад этгээдийн оруулсан мөнгө, эд хөрөнгө; Сангийн үйл ажиллагаанаас олсон орлого.
Гүрж	Төрийн тусгай зориулалтын санг байгуулсан. Тусгайлсан хуульгүй. Гэр бүлийн х ү ч и р х и й л э л т э й тэмцэх, Хүн х у д а л д а а л а х т а й тэмцэх тухай болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудаар зохицуулдаг.	Хүн худалдаалах болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид нөхөн олговор олгох зохицуулалтыг холбогдох хуулиудад тусгасан. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хуулийн ⁵⁹ дагуу иргэний болон эрүүгийн журмаар хохирогчид учирсан сэтгэл санааны, биет, эд хөрөнгийн хохирлыг барагдуулдаг. Хэрвээ гэм буруутай этгээд төлж барагдуулах боломжгүй бол Төрийн сангаас нөхөн олговор олгодог. Дээрх хуулийн 9-р зүйлд заасны дагуу хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, тэдэнд туслах, нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилгоор 2006 оны 6-р сард Төрийн санг байгуулсан. ⁶⁰ Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг Гүрж улсын Хөдөлмөр, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам гүйцэтгэдэг.

(2019) p.20 https://victimsupport.eu/activeapp/wp-content/uploads/2019/08/VOCIARE_National_Report_Hungary_interactive.pdf

⁵⁷ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=33075&lang=ENG (Crime victim protection fund act)

⁵⁸ БНСУ-ын эрх зүйн мэдээллийн систем. <https://bit.ly/2Wz17y9>

⁵⁹ Закон о борьбе против торговли людьми (трефикинга) (2006.04.28)

⁶⁰ Вебсайт Государственного фонда. <http://www.atipfund.gov.ge/index.aspx>

Карим Восток – Консорциум прикладных исследований по международной миграции. Натия Челидзе. Торговля людьми: Грузия. Пояснительная записка 13/34. Социально-политические рамки миграции. (2013) https://cadmus.eui.eu/bitstream/handle/1814/62796/Explanatory%20Notes_2013-34.pdf?sequence=1&isAllowed=y

Хүснэгт 2.1-ийн үргэлжлэл

Улс	Санг байгуулсан эрх зүйн зохицуулалт	Тайлбар
Япон	Гэмт хэргийн хохирол барагдуулах сантай. Гэмт хэргийн хохирогчийн тухай хууль, 2004 он	Япон Улс нь гэмт хэргийн хохирогчдын нас, эрүүл мэндийн онцлогт тохирсон үйлчилгээ, нөхөн олговор, тэтгэмж олгодог. ⁶¹ Гэмт хэргийн хохирол барагдуулах санг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан ба тус сангийн эх үүсвэр нь төвлөрүүлсэн төсөв, хандиваас бүрдэнэ. ⁶²
Канад	Хохирогчдын сантай Канадын Холбооны улсын “Хохирогчийн эрхийн билл” буюу хууль, 2015 он ⁶³	Хохирогчдын хохирлыг барагдуулах чиглэлээр Канадын нэгдсэн стандарт, хэм хэмжээ байдаггүй. Гэсэн хэдий ч Холбооны засгийн газар тодорхой хохирогчдод зориулсан хязгаарлагдмал хоёр хөтөлбөрийг нэвтрүүлсэн: 1) гадаадад хохирогч болсон канадууд, 2) амиа алдсан буюу хүн амины гэмт хэргийн хохирогч болсон, мөн сураггүй болсон хүүхдүүдийн эцэг эхчүүд. 2007 оноос хойш тус улсын засгийн газар гадаадад үйлдэгдсэн хүчирхийллийн зарим хохирогчид (гэр бүлийн хүрээн дэх хүн амины хэрэг, бэлгийн хүчирхийлэл, хүнд хэлбэрийн хүчирхийлэл, бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн) болон тэдний гэр бүлийн гишүүдэд 10,000 доллар хүртэлх санхүүгийн тусламж үзүүлэхээр санал болгосон. Хохирогчдын сан нь хохирогчдын бие махбодод учирсан хохирлын нөхөн төлбөрийг өгдөггүй боловч хэрэв хохирогч санхүүгийн туслалцаа үзүүлэх өөр эх үүсвэргүй бол гадаадад эмчлүүлэх зардлаа нөхөн олгох, хулгайд алдсан бичиг баримтыг нь солих, зөвлөгөө өгөх, нас барсан тохиолдолд оршуулгын зардалд туслалцаа үзүүлдэг.
ОХУ	Тусгайлсан сан байхгүй. Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Иргэний хуульд заасан зохицуулалтаар хохирол, нөхөн төлбөр олгодог.	Оросын Холбооны Улсын хувьд хохирлын нөхөн олговорт зориулан тусгай сан байгуулахаар Төрийн Думын хэмжээнд хэлэлцэгдэж байгаа ба 2020 оноос энэ асуудлыг төрийн дээд удирдлагын түвшинд авч үзэх болсон. ОХУ-д өнөөгийн байдлаар гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох тогтолцоо бүрэн бүрдээгүй байна. ⁶⁴

⁶¹ Crime Victim Support of Japanese <https://bit.ly/3ngsBTS>; <https://bit.ly/3DYX270>; <https://bit.ly/3hfSMWZ>

⁶² Япон Улсын Гэмт хэргийн хохирол барагдуулах сан үүсгэн байгуулах тухай тогтоолын 6-р зүйл

⁶³ Victim services. <https://www.justice.gov.nt.ca/en/victim-services/>

⁶⁴ Правительство РФ призвали создать фонд помощи жертвам преступлений. (2020.02.26) <https://regnum.ru/news/2868270.html>

2.4 ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙГ НӨХӨН БАРАГДУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Хохирлын үндэсний тогтолцоо. Монгол Улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал” судалгааны зөвлөмжид “Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлд нийцүүлэн гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоох, үнэлэх, нөхөн барагдуулах суурь тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай; гэмт хэргийн улмаас бие махбод, сэтгэл санаанд учирсан хохирлын үнэлгээний заавар журам, аргачлалыг шинээр боловсруулж хэрэгжүүлэх, үүний тулд Эрүүгийн хуулийн үзэл баримтлалд нийцсэн, хүний бие махбод, эд эрхтний үнэлгээг бий болгох нь зүйтэй; бусад орны сайн жишгийг судлах замаар сэтгэл санааны хохирлыг тооцож үнэлэх, нөхөн олгох эрх зүйн орчин, практикийг бий болгох шаардлагатай; гэмт хэргийн хор уршгийг үнэлэх илтгэлцүүр, жишиг гарган мөрдүүлэх; гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг зөв тогтоох, бодит үнэлгээг гаргуулах, нөхөн төлөлтийг баталгаатай болгох зорилгоор хөрөнгө битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагааг мөрдөн шалгах явцад өргөн хэрэглэх хэрэгтэй; олон улсын сэтгэцийн өвчний ангилалд нийцүүлсэн сэтгэл зүйн хохирол, хор уршгийг тооцох аргачлал, эдийн болон эдийн бус хөрөнгийг үнэлэх жишиг аргачлал батлах шаардлагатай”-г тус тус дурдсан билээ.⁶⁵

Судалсан улс орнуудын хувьд мөрдөн байцаалт болон шүүхийн шатанд хэдийд ч хохирлын хэмжээг тогтоох, түүнийг үнэлэх, барагдуулах нь мөрдөн шалгах тодорхой төрлийн ажиллагаануудаас бүрдэх ба энэ нь нотолгооны арга хэрэгслээс хамаардаг нь манай улстай ижил байдаг. Монгол Улсад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх тусгайлсан эрх зүйн зохицуулалт, арга хэрэгсэл байхгүй учраас хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх талаарх гадаад улсын туршлага, олон улсын чиг хандлагыг судаллаа.

⁶⁵ Нээлттэй Нийгэм Форум, Монголын Криминологичдын холбоо. Хохирлын үндэсний тогтолцоо. Монгол Улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал. Цуврал судалгаа №1. 91-92 дахь тал

Хүснэгт 2.2. Улс орнуудын гэмт хэргийн хохирол, хор уршиг барагдуулах талаар гомдол гаргах эрх, хугацаа, хэмжээ хязгаар

Улс орон	Гэмт хэргийн хохирол, хор уршгийг барагдуулах талаар гомдол гаргах эрх, хугацаа, хэмжээ хязгаар ⁶⁶
ХБНГУ	<p>Хохирогч гэмт хэргийн талаар Цагдаагийн байгууллагад мэдэгдэж, хуульд заасан хугацаанд өргөдлийг гаргаж цагдаагийн байгууллагад бүртгүүлсэн байх, хохирогч цагдаагийн болон прокурорын байгууллагатай хамтран ажилласан байх. Гэмт хэргийн ангилал, төрлөөс хамаарч 3 сараас 30 жил⁶⁷-ийн дотор нөхөн төлбөр авах хүсэлт гаргах эрхтэй. Ихэнх тохиолдолд 1 жилийн дотор гомдол гаргах хугацааг баримталдаг. Хэрвээ нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэгдвэл гэмт хэрэг гарсан өдрөөс биш өргөдөл гаргасан өдрөөр нөхөн төлбөрийг олгоно. Гадаад улсын иргэний хувьд Европын Холбооны улсуудын хооронд харилцан тохиролцсон холбооны иргэд нөхөн төлбөр авах эрхтэй байна. Мөн гадаадын иргэн ХБНГУ-тай хоёр талын хэлэлцээртэй улсын иргэн бол нөхөн төлбөр авах эрхтэй байх бөгөөд мөн ХБНГУ-д албан ёсоор 3 жилийн хугацаанд амьдарч байгаа гадаадын иргэн нөхөн төлбөр авах эрхтэй байдаг байна. Хохирогч гэмт хэрэг гарсан өдөр, байршил, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэмтлийн талаар цагдаагийн байгууллагад заавал мэдэгдэх ёстой байдаг. Өргөдөл гаргагчийн өргөдлийг хүлээн авснаас хойш 6 сарын дотор гаргасан шийдвэрийн талаар өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.</p>
Эстони	<p>Хохирогч нь гэмт хэрэг үйлдсэн, хохирол учруулсан санаатай эсвэл болгоомжгүй үйлдэл гаргасан, хохирогч тодорхой заасан хүчирхийллийн гэмт хэрэг шийдвэрлэгдсэнээс хойш нөхөн төлбөр авахаар 15 хоногийн дотор мэдэгдэх ёстой. Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Эстонийн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь өргөдлийг хянаж үзээд шийдвэр гаргах ёстой.</p>

⁶⁶ Info Victims. Country Profile: Germany <http://www.infovictims.com>

⁶⁷ Мөн тэнд

Хүснэгт 2.2-ын үргэлжлэл

Улс орон	Гэмт хэргийн хохирол, хор уршгийг барагдуулах талаар гомдол гаргах эрх, хугацаа, хэмжээ хязгаар ⁶⁸
Унгар	Гэмт хэрэг гарсан, тухайн хэргийг шийдвэрлэснээс хойш 6 сарын дотор гомдол гаргах эрхтэй. Унгар улсад нөхөн төлбөр авах өргөдлийн стандарт маягт байдаг. Нөхөн төлбөр авах өргөдлийг стандарт маягтын дагуу бөглөнө. ⁶⁸ Өргөдлийг шийдвэрлэх эрх бүхий байгууллага нь нийслэлийн засгийн газрын алба бөгөөд, мужуудад хохирогчийг дэмжих үйлчилгээ үзүүлэх туслах байгууллага байдаг. Нөхөн олговор авах өргөдлийн маягтыг хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаанд нь гаргаж чадаагүй бол гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор гаргаж болно.
Япон	Хохирогч гэмт хэргийн талаар Цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ /хэзээ ч мэдэгдэж болно/. Өргөдөл гаргагч 2 жилийн дотор гэмт хэрэг гэж үзсэн буюу гэмт хэрэг гарснаас 7 жилийн дотор өргөдөл гаргасан байх ба гомдлыг Цагдаагийн байгууллагад гаргасан байх. Цагдаагийн газарт заавал гомдол гаргана. Цагдаагийн байгууллага нь гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг тогтоосон байна. Гомдол гаргагч өргөдлийн маягтыг цагдаагийн байгууллагаас авч, гомдол гаргагч өргөдлөө харьяа нийтийн хамгаалах байгууллага руу тухайн өргөдөл гаргагчийн оршин суугаа цагдаагийн байгууллагаар дамжуулан хүргүүлсэн байна. Өргөдлийг хүлээн авсан байгууллага нь ойролцоогоор 5 сарын дараа шийдвэр гаргах бөгөөд үүнээс 2 долоо хоногийн дараа өргөдөл гаргагчид зохих хэмжээний төлбөрийг олгоно.
БНСУ	Хохирогч нь гэмт хэргийн талаар мэдээлсэн өдрөөс хойш 1 жилийн дотор, гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш 5 жилийн дотор нөхөн төлбөр авахаар гомдол гаргах эрхтэй. Өргөдлийн маягтыг Цагдаагийн хэлтэс эсвэл Төрийн үйлчилгээний төвийн прокурорын газраас авах боломжтой. Хохирогч, өргөдөл гаргагчийн хэлснээр гэмт хэргийн шинжтэй үйл явдлыг цагдаа, прокурор шалгаж, баталгаажуулсан тохиолдолд өргөдлийг хянан шийдвэрлэж, нөхөн төлбөр төлөх эсэх талаар шийдвэр гаргана. Хохирогчид нөхөн олговор олгох хөтөлбөрийг БНСУ-ын төсвөөс санхүүжүүлдэг.

⁶⁸ European Network on Victims' Rights. Hungary. <https://envr.eu/hungary/>

Хүснэгт 2.2-ын үргэлжлэл

Улс орон	Гэмт хэргийн хохирол, хор уршгийг барагдуулах талаар гомдол гаргах эрх, хугацаа, хэмжээ хязгаар ⁶⁶
Канад	Канадын ихэнх гэрч хохирогчид туслалцаа үзүүлэх хөтөлбөрүүд гэмт хэргийн хохирол учирснаас 1-2 жилийн дотор нөхөн төлбөр авах хүсэлт гаргахыг шаарддаг. Гэхдээ гурван муж (British Columbia, Nova Scotia, Quebec) нь бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэх мэт тодорхой гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уян хатан байдлаар тогтоосон. Квебек мужийн иргэний хууль тогтоомжоор шүүхэд нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил байдаг бол гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр авах өргөдөл гаргахад ердөө хоёр жилийн хугацаатай байдаг. Онтарио мужийн хувьд 2019 онд хохирогчдод түргэн шуурхай үйлчлэх хөтөлбөрөөрөө 2 жилийн хөөн хэлэлцэх хугацааг богиносгосон.
Польш	Гэмт хэргийн хохирогчоор тогтоосон даруйд Гэмт хэргийн хохирогчийг дэмжих үйлчилгээний талаар мэдээлэх нь цагдаагийн хуулиар хүлээсэн үүрэгт багтдаг. Уг үйлчилгээ нь зөвлөгөө, мэдээлэл, сэтгэл санааны дэмжлэг, хуулийн туслалцаа, хүнд нөхцөл байдалд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр үйл ажиллагаагаа явуулдаг.
Гүрж	Гүрж Улсад хохирол барагдуулахдаа Иргэний хуулийн механизмыг ашигладаг болохыг дээр дурдсан билээ. Иргэний хууль дахь гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах зохицуулалтын ⁶⁹ дагуу хохирогч төрөөс эмнэлгийн болон сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцаа, орлогоо алдсаны нөхөн төлбөр авах боломжтой. Терроризмын хохирогч болсон бол Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санхүүгийн туслалцаа авах хүсэлтээ гаргана. ⁷⁰

Гэмт хэргийн улмаас нөхөн олговор авах талаар гомдол, хүсэлт гаргах хугацаа нь судалсан улс орнуудын хувьд 15 хоногоос 5 жилийн дотор гаргаж болохоор харилцан адилгүй байгаа ба энэ нь гэмт хэргийн талаар гомдол мэдээлэл гаргах тогтолцоотой холбоотой гэж үзэж болохоор байна.

⁶⁹ Гүрж Улсын Иргэний хууль. (1997.07.24) <https://matsne.gov.ge/en/document/view/31702>

⁷⁰ Би гэмт хэргийн хохирогчийн хувьд ямар эрхтэй вэ? <https://bit.ly/3DDJqOG>

График 2.3. Хохирол нөхөн төлүүлэх процесс



Гэмт хэргийн хохирлын нөхөн төлбөр авах гомдол, мэдээлэл гаргах эрх нь:

- Тухайн хэрэг гарсныг тогтоосны дараа;
- Тухайн хэрэгт хохирогчоор тогтоосны дараа;
- Тухайн хэргийн мөрдөн байцаалт дууссаны дараа;
- Тухайн хэргийн шүүхийн шийдвэр гарсны дараа гэсэн ялгаатай тохиолдлууд байх ба аль ч тохиолдолд тухайн гэмт хэрэг бүртгэгдсэн байх, тухайн хохирол учирсныг нотлох баримт байх гэсэн 2 шаардлагыг тавьсан байна.

Энэ нь эрүүгийн эрх зүйн онцлог болох үйл баримтыг нотолгооны арга хэрэгслээр тогтоосон байх гэсэн үндсэн шаардлагад тулгуурлажээ.

Хүснэгт 2.3. Улс орнуудын гэмт хэргийн хохирол, хор уршгийн нөхөн төлбөр авах субъект, нөхөн төлбөрийн төрөл

Улс орон	ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙН НӨХӨН ТӨЛБӨР АВАХ СУБЪЕКТ, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТӨРӨЛ
ХВНГУ	<p>Хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуульд заасны дагуу хүч хэрэглэсэн гэмт хэргийн хувьд хохирогч бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн бүх хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй. Эрүүл мэндэд учирсан хохирлын улмаас үүссэн эдийн засгийн хохирлыг мөн нөхөн төлнө.</p> <ul style="list-style-type: none">• Богино болон урт хугацааны эмчилгээ;• Туслах хэрэгсэл (жишээ нь протез, шүдний протез, тэргэнцэр);• Хохирогч болон амьд үлдсэн асран хамгаалагчдад олгосон нөхөн төлбөр;• Оршуулгын тэтгэмж;

Улс орон	ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙН НӨХӨН ТӨЛБӨР АВАХ СУБЪЕКТ, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТӨРӨЛ
	<ul style="list-style-type: none"> • Амьдралын наад захын хэрэгцээ гарсан тохиолдолд бусад халамжийн тэтгэмж (жишээлбэл, урт хугацааны асрамж, амьжиргааны тэтгэмж). <p>Нөхөн төлбөр авах субъект</p> <ul style="list-style-type: none"> • Санаатай, хууль бусаар үйлдсэн бие махбодын хүчирхийллийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон хохирогчид болон аргагүй хамгаалалт хийсэн субъект • Хохирогчоос гадна гэмт хэрэгт шууд бусаар өртсөн хүмүүс, • Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид нөхөн төлбөр авах эрхтэй (гэр бүлийн гишүүд, хамаарал бүхий харилцаатай хүмүүс) • Хэрэв хохирогч нас барсан бол ойр дотнын зарим хүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрхтэй байдаг. • Тус улсад байнга (3 жилээс дээш) оршин суудаг иргэн
Эстони	<p>Нөхөн олговрыг хөдөлмөрийн чадвар алдах эсвэл хөдөлмөрийн чадвар буурснаас үүдэлтэй хохирол, хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирлын улмаас гарсан зардал, хохирогч нас барсны улмаас учирсан хохирол, хохирогчийн оршуулгын зардал, нүдний шил, хиймэл шүд, контакт линз болон биеийн үйл ажиллагааг орлох бусад хэрэгсэлд учирсан гэмтэл, 16 ба түүнээс дээш насны хохирогчдод хөдөлмөрийн чадвар алдах, хөдөлмөрийн чадвар буурснаас үүдсэн хохирлын үндсэн дээр нөхөн олговрын хэмжээг тодорхойлно.</p> <p>Хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирлын улмаас гарсан зардал нь хохирогчийн эрүүл мэндтэй холбоотой зайлшгүй зардал юм. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн эмчилгээ; • Эмнэлгийн нөхөн сэргээлт; • Орлуулах эм, бүтээгдэхүүн худалдан авах; • Биеийн үйл ажиллагаа, гэмтлийн дараах бие махбодын болон сэтгэцийн хүндрэлийг бууруулах; • Эрүүл мэндийн байдалд тохирсон ажил, мэргэжил эзэмшихтэй холбогдон гарсан зардал. <p>Эстони Улсад дараах хүмүүс нөхөн төлбөр авах эрхтэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч; • Эстонид байнга оршин суудаг гадаадын иргэн эсвэл Эстонид байнга оршин суудаггүй, гадаадад байсан

Хүснэгт 2.3-ын үргэлжлэл

Улс орон	ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙН НӨХӨН ТӨЛБӨР АВАХ СУБЪЕКТ, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТӨРӨЛ
	<ul style="list-style-type: none"> • Эстонийн иргэн; • Удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл, түр оршин суух зөвшөөрөл эсвэл оршин суух эрхийн үндсэн дээр Эстони улсад амьдарч буй хүмүүс; • Европын холбооны иргэд; • Хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай Европын конвенцод нэгдэн орсон улсын иргэд; • Хэрэв хохирогч нас барвал нөхөн төлбөрийг тухайн үед Эстони улсад байнга оршин сууж байсан хамаарал бүхий хүнд олгоно.
Унгар	<p>Унгар Улсын хувьд бие махбодын бүрэн бүтэн байдал, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулсан санаатай гэмт хэргийн хохирогч, нас барсан хохирогчийн хувьд шууд хамаатан садан, үрчилж авсан эцэг, эх, асран хүмүүжүүлэгч, асран хамгаалагч, хань ижил, хамтран амьдрагч нөхөн төлбөр авах эрхтэй. Мөн хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан хохирогчийн асран хамгаалалтад байсан хүн шүүхийн шийдвэр, албан ёсны хүчин төгөлдөр гэрээний үндсэн дээр нөхөн төлбөр авах эрх үүснэ. Санаатай гэмт хэргийн улмаас нас барсан хохирогчийг оршуулах ажлыг зохион байгуулсан хүн оршуулгын зардлыг нэхэмжилж хүсэлт гаргах эрхтэй.</p> <p>Унгар Улсын иргэн, Европын Холбооны гишүүн улсын иргэн, Европын Холбооны нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин сууж буй Европын холбооны гишүүн бус аливаа улсын иргэн, Унгар Улсын нутаг дэвсгэрт хууль ёсны дагуу оршин сууж буй харьяалалгүй хүмүүс, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, мөн бусад улстай байгуулсан олон улсын гэрээний дагуу зохих эрхтэй гэж үзсэн бусад хүн нөхөн төлбөр шаардах эрхтэй.</p>
Япон	<p>Гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл учирсан бөгөөд хууль ёсоор Япон улсад амьдарч байгаа гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлийн гишүүд, гадаад улсын иргэн нь гэмт хэрэг гарах үед Японд хууль ёсоор байсан иргэн нөхөн төлбөр авах эрхтэй.</p> <p>Хөтөлбөрийн дагуу эмчилгээний зардал, цалин хөлс, гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлд олгох нөхөн олговрыг бүхэлд нь олгодог байна. Нөхөн олговрыг нь учирсан хохирол, хор уршгийн нөхцөл байдлаас хамааран мөнгөн хэлбэрээр олгодог.</p>

Улс орон	ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙН НӨХӨН ТӨЛБӨР АВАХ СУБЪЕКТ, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТӨРӨЛ
БНСУ	<p>Гэмт хэргийн хохирогч хүнд гэмтсэн, нас барсан тохиолдолд хохирол учруулагчийг илрүүлээгүй, эсвэл хохирол учруулагч хохирлыг бүрэн, эсвэл хэсгийг нь төлөх санхүүгийн бололцоогүй бол улсаас хохирогчид, хэрэв нас барсан бол гэр бүлийн гишүүдэд нь тодорхой хэмжээний нөхөн олговор олгодог.</p> <p>Гэрчийг хамгаалах сангийн тухай хууль болон түүнд нийцүүлэн баталсан журмыг үзвэл гэмт хэргийн улмаас учирсан эрүүл мэндийн хохирол, хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх нь тодорхой тогтоосон хэмжээтэй байдаг. Тухайлбал, нөхөн олговор дараах төрөлтэй байна:</p> <ul style="list-style-type: none"> · Хөдөлмөрийн чадвараа алдсаны тусламж · Гэр бүлд туслах сан · Онцгой байдлын үеийн нөхөн олговор <p>Нөхөн олговор авах эрх бүхий этгээд:</p> <ul style="list-style-type: none"> · Нас барсан этгээдийн гэр бүл: эхнэр/нөхөр, хүүхэд, эцэг эх, ач зээ, эмээ өвөө, ах/эгч дүү · Хөдөлмөрийн чадвар алдагдсаны олговор: 1-6 дугаар түвшний гэмтэл авсан хүмүүс · Хууль ёсны дагуу байнга оршин сууж байгаа гадаад улсын иргэд
Канад	<p>Нөхөн олговрын төрөл:</p> <ul style="list-style-type: none"> · Тэтгэмж <p>Канад улсын мужуудын гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх тэтгэмж харилцан адилгүй байдаг. Нөхөн төлбөрийн гол ангилал нь эмчилгээний зардал, дутуу авсан цалин, хөлс, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ болон оршуулгын зардал, хэргийн газрын цэвэрлэгээ, хагалсан нүдний шил засвар гэх мэт хэрэглээг багтаадаг.</p> <ul style="list-style-type: none"> · Эмнэлгийн зардал <p>Жишээлбэл, Онтарио хотод хохирогчид эмчилгээний зардлаа нийгмийн эрүүл мэндийн даатгалаас авах ёстой боловч зохих хохирогчид шүдний зардал, хиймэл эрхтэн, физик эмчилгээний нөхөн төлбөрийг авч болно.</p> <ul style="list-style-type: none"> · Орлого, цалин, хөлсний нөхөн олговор · Сэтгэцийн эрүүл мэндийн хохирол <p>Нөхөн төлбөр авах субъект нь гэмт хэргийн хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, байнга оршин суудаг гадаад улсын иргэд байна.</p>

Аль ч улс орны хувьд эрүүл мэндийн хохиролд бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн хохирлыг багтаасан байх ба олох ёстой байсан орлого, тэжээгчээ алдсан тэтгэмж, нөхөн сэргээхэд гарсан болон эмчлүүлэхэд гарсан зардал зэргийг төрөлжүүлсэн хууль болон журамд тусгайлан зааж өгчээ. Азийн улс орнууд болох Япон, БНСУ-ын хувьд нөхөн төлбөрийн төрлийг заахгүйгээр харин шалгуурын хүрээнд субъектээс хамаарч тодорхой олгох мөнгөн дүнг хоёроос гурван ангилалд авч үзэж байна. Европын орнууд болох ХБНГУ, БНПУ-д нөхөн төлбөрийн төрөл хэмжээг тогтоох, үнэлэх асуудлыг Эрүүгийн болон Иргэний хууль тогтоомжоор шийдвэрлэж байна. Эрүүгийн эрх зүйн харилцааны онцлогоос хамаарч нөхөн төлбөрийг зөвхөн гэмт хэргийн хохирогч тус улсын иргэн, тухайн улсад байнга оршин суудаг гадаад улсын иргэн, түүний хууль ёсны төлөөлөгч авч болохоор ихэнх улс орнууд зохицуулсан. Зарим улсад (ХБНГУ, Унгар, Польш, Эстони) тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогч гэмт хэргийн улмаас шууд бусаар хохирсон хүн, тухайн бүс нутгийн иргэн (Европын Холбооны) нөхөн төлбөр авах субъект байхаар заасан.

Хүснэгт 2.4. Улс орнуудын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох үнэлэх, түүнийг олгох субъект

Улс орон	НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ҮНЭЛЭХ, ТҮҮНИЙГ ОЛГОХ СУБЪЕКТ
ХБНГУ	<p>ХБНГУ-ын хувьд сэтгэл санааны гэм хорыг арилгах тусгай аргачлал байхгүй бөгөөд өмнө гарсан шүүхийн шийдвэрийг баримжаа болгодог байна. Хохирлын хэмжээг тодорхойлохдоо хариуцагчийн гэм буруу, хохирогчид бий болсон сөрөг үр дагавар, хариуцагчийн эд хөрөнгийн байдал зэргийг харгалзан үздэг. ХБНГУ-ын Иргэний хуулиар сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх асуудлыг шийдвэрлэхдээ хариуцлага ногдуулах үндэслэл болох эдийн бус баялгийг дордуулснаас шаналал үүссэн эсэх, гэм хор учруулагчийн хууль бус үйлдэл байгаа эсэх, тэдгээрийн хоорондын шалтгаант холбоо, гэм хор учруулагчийн гэм буруутай байдал зэргийг шалгадаг байна.</p> <p>Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо Иргэний хуулийн 249 дүгээр зүйлд заасан ашгийг тэнцвэртэй байлгах зарчмыг баримталдаг байна. Өөрөөр хэлбэл, хохирогч нь өөрт учирсан хохирлоосоо давах илүү нөхөн төлбөр авах ёсгүй гэсэн үг юм. Нөхөн төлбөрийн хэмжээг шүүх тогтоохдоо өмнөх онд энэ төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрээр тогтоосон хэмжээ, улсын нийгэм, эдийн засгийн байдалд гарсан өөрчлөлт зэргийг харгалзан үздэг.</p>

Хүснэгт 2.4-ийн үргэлжлэл

Улс орон	НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ҮНЭЛЭХ, ТҮҮНИЙГ ОЛГОХ СУБЪЕКТ
	<p>Гэсэн хэдий ч шүүхийн олон шийдвэрээр тогтоогдсон хэмжээ мөнгөний инфляцын түвшинд баригдах боломжгүй байсан нь хүндрэл учруулсан тул энэ асуудлыг шийдвэрлэхээр Шнайдер, Цельнерийн аргыг боловсруулжээ.⁷¹</p> <p>Энэ нь өмнөх шүүхийн шийдвэрээр тогтоогдсон нөхөн төлбөрийн хэмжээг дараагийн хэрэг маргааныг авч хэлэлцэх үеийн хэрэглээний индексийн өөрчлөлттэй уялдуулах арга юм.</p> <p>Түүнчлэн шүүх дараах төрлөөр нөхөн төлбөрийг тогтоодог. Үүнд⁷²:</p> <ul style="list-style-type: none"> • Орлогын алдагдал • Өвчин ба зовлон, шаналлын зардал • Арчилгааны зардал / Тусламж, эрүүл мэндийн үйлчилгээ • Амьжиргааны зардлын нөхөн олговор • Хүний амь насны эсрэг гэмт хэрэгт хохирол барагдуулах.
Эстони	<p>Хөгжлийн бэрхшээлтэй болох, хөдөлмөрийн чадвараа алдахтай холбоотой хохирлыг ажиллаж байсан гэрээ, цалингийн тодорхойлолт, олж байсан орлогын хэмжээг үндэслэн нөхөн төлнө. Хувиараа бизнес эрхлэгчдийн хувьд нөхөн олговрыг сарын хугацаанд олсон цэвэр орлогод үндэслэн тооцно. Хүчирхийллийн гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд учирсан хохирлыг Эстонийн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно. Хэрэв нэг сарын орлого нь тогтоосон сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байвал сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30-д хувааж тооцно.</p> <p>Хохирогч нас барсан бол түүний хууль ёсны төлөөлөгчид 448 еврогийн нөхөн төлбөр нэг удаа олгоно. Хүчирхийллийн гэмт хэргийн улмаас нас барсан хохирогчийн асрамжид байгаа хүмүүст хохирлыг үндэслэн нөхөн төлбөр олгоно. Хохирогчийн орлогыг дараах байдлаар тооцож олгоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Нэг хүн хамааралтай бол орлогын 75 хувь; • Хоёр хүн хамааралтай бол орлогын 85 хувь; • Гурав ба түүнээс дээш хараат хүмүүсийн хувьд орлогын 100 хувь. <p>Нөхөн олговрыг Эстонийн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно. Нэг хохирогчид төлөх нөхөн төлбөрийн хэмжээ 9590 еврогоос хэтрэхгүй байх ёстой.</p>
Унгар	<p>Унгар Улсад хохирол барагдуулахдаа Иргэний хуулийн 18 дугаар зүйл (Хувь хүний эдийн бус эрх)-ийн 18.6 заалтын дагуу хохирогч эдийн бус хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах боломжтой. Эдийн бус хохирлыг эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлсөн эсэхээс үл хамааран нөхөн төлүүлнэ.</p>

⁷¹ Эрделевский А.М “Компенсация морального вреда” Москва, Издательство БЕК, 2000 он, 61 дэх тал

⁷² Swissre. Bodily injury landscape Europe: Germany (2018) <https://bit.ly/3mQyHKs>

Хүснэгт 2.4-ийн үргэлжлэл

Улс орон	НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ҮНЭЛЭХ, ТҮҮНИЙГ ОЛГОХ СУБЪЕКТ
Гүрж	<p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль (2006)⁷³-ийн 16 дугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч өөрт учирсан хохирол, хор уршгийг нөхөн барагдуулахыг шаардах эрхтэй болохыг зохицуулжээ. 16.1-д зааснаар хохирогч өөрт учирсан сэтгэл санааны, биет, эд хөрөнгийн хохирлыг барагдуулахыг иргэний болон эрүүгийн процессын хууль тогтоомжийн дагуу шаардах эрхтэй. 16.2-т зааснаар дээрх хохирлыг гэмт этгээд барагдуулах боломжгүй бол нөхөн олговрыг Төрийн сангаас олгоно.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг, хохирогчийг дэмжих, хүчирхийллээс хамгаалах тухай хууль⁷⁴ 2006 оны 5-р сарын 25-ны өдөр батлагдсан. Зорилго нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогчдод нийгмийн болон эрх зүйн хамгаалалт, туслалцаа олгох асуудлыг зохицуулахад оршино. Тус хуулийн 7-р бүлгийн 21-р зүйлийн 21.11-д зааснаар Гүрж Улсын Засгийн газар хохирогчдод олгох нөхөн төлбөрийн хэмжээ, журмыг батлан мөрдүүлж байна.</p>
Япон	<p>Гэмт хэргийн хохирогчийн алба нь улсын төсвөөс санхүүждэг бөгөөд гэмт хэргийн улмаас өнчирсэн хүүхэд болон гэмт хэргийн хохирогч нарт дэмжлэг үзүүлэх туслах сангаар дамжуулан тэтгэлэг олгоно. Гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл учирсан бөгөөд хууль ёсоор Япон улсад амьдарч байгаа гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлийн гишүүд, гэмт хэрэг гарах үед Япон улсад хууль ёсоор оршин сууж байсан гадаад иргэн нөхөн төлбөр авах өргөдөл гаргаж болно. Гомдлыг хүлээн авсан байгууллага нь ойролцоогоор 5 сарын дараа шийдвэр гаргах бөгөөд үүнээс 2 долоо хоногийн дараа өргөдөл гаргагчид зохих хэмжээний төлбөрийг олгоно.</p> <ul style="list-style-type: none"> • Хохирогчийн гэр бүлд 10,179,000 иен (\$92,628.9) болон үндэслэл бүхий шийдвэрээр тогтоосон нөхөн олговорт 12,730,000 иен олгоно. (\$115,843) • Хохирогч нас барахын өмнө гарсан эмчилгээний зардлын нөхөн төлбөрт 10,790,000 (\$98,189) (2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчид 15,730,000 иен (\$143,143)) олгоно. • Хөдөлмөрийн чадваргүй болсны нөхөн төлбөрт 12,730,000 иен (\$115,843) (2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчид 18,492,000 иен (\$168,277.2)) олгоно. <p>Хөтөлбөрийн дагуу эмчилгээний зардал, цалин хөлс, гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлд олгох нөхөн олговрыг бүхэлд нь олгодог. Хэрвээ нөхөн төлбөр олгох тухай шийдвэрийг яаралтай</p>

⁷³ Закон Грузии О борьбе против торговли людьми (трефикинга). (2006.04.28) <https://bit.ly/3kFARds>

⁷⁴ О пресечении насилия в семье, защите и оказании помощи жертвам насилия в семье (2006) <https://bit.ly/38uamlt>

Хүснэгт 2.4-ийн үргэлжлэл

Улс орон	НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ҮНЭЛЭХ, ТҮҮНИЙГ ОЛГОХ СУБЪЕКТ
	<p>гаргах боломжгүй бол, мөн гэмт хэрэгтэн болон гэмт хэргийн хохирол тодорхой бус байвал өргөдөл гаргагчид урьдчилсан нөхөн олговрыг хөтөлбөрийн дагуу олгоно.⁷⁵ Гэмт хэргийн хохирогчийн ерөнхий хууль (2004)⁷⁶ -иар ерөнхий заалт, үндсэн бодлогууд, гэмт хэргийн хохирогчдод чиглэсэн бодлогыг дэмжих зөвлөлийн асуудлыг зохицуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • Хохирогч нас барсан тохиолдолд ₮29,645,000 - ₮8,721,000 иен (\$269769.5 – \$79361.1) нөхөн олговрыг гэр бүлийн гишүүдэд олгоно. Нас барахаас өмнөх 3 сарын дотор эмнэлгийн зардалд ₮12,100,000 - ₮3,200,000 иен (\$110,110 – \$29120) төлбөрийг гэр бүлийн гишүүдэд нэмж олгоно. • Хүнд гэмтэл учирсны улмаас 1 жилийн дотор эмчлүүлсэн тохиолдолд холбогдох зардалд ₮1,200,000 иенээс (\$10,920) дээшгүй нөхөн төлбөр олгоно. • Хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд 1-14 түвшнээр ангилах бөгөөд ₮39,744,000 - ₮10,560,000 иений (\$361,670.4 - \$96,096) нөхөн олговор олгоно. Үүнд эмчилгээний зардал 12,696,000 - 180,000 иен (\$115,533.6 – \$1,638) нэмж олгох боломжтой. (Гэмт хэргийн хохирогчдод олгох нөхөн олговрын тогтолцоо⁷⁷)
Канад	<p>Альберта гэх мэт бусад хөтөлбөрүүд эмнэлгийн үйлчилгээний зардлыг тусгайлан тусгаагүй бөгөөд оронд нь тусгай үнэлгээний тогтолцоог ашигладаг. Нөхөн олговрыг учирсан хохирлын хэмжээгээр тодорхойлно. Гэмтлийн төрөл бүрийг оноогоор үнэлж, эргээд хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлдог. Жишээлбэл, амьсгалын замын цочрол нь 1,408-ийн зэрэглэлтэй байдаг бол доод мөчийг өвдөгнөөс доош тайрахад хүрсэн тохиолдолд 80,103 гэж үнэлдэг бөгөөд хөдөлгөх булчин, мэдрэхүйн үйл ажиллагаа алдагдсан нугасны гэмтэл 217,299 гэсэн үнэлгээтэй байдаг. Сэтгэлзүйн гэмтэл нь 19,23 оноо авсан боловч хохирогчийн нас, олон түрэмгийлэгч оролцсон эсэхээс хамаарч өөр өөр байж болно. 2,5-аас 4,99 оноо авсан хохирогч 500 доллар авах эрхтэй бөгөөд энэ нь хамгийн бага тэтгэмж юм. Боломжит хамгийн өндөр нөхөн олговрын хэмжээ 110,000 доллар бөгөөд тухайн хүн 210 ба түүнээс дээш оноо авсан байх ёстой. Тиймээс нөхөн олговор нь хохирогчийн хэрэгцээг бус хохирлын үр дагаврыг үндэслэдэг.</p> <p>Нова Скотиа мужийн хөтөлбөрөөр гагцхүү зөвлөх үйлчилгээ санал болгодог ба хохирогч бүрд 2000 долларын нөхөн төлбөрөөр хязгаарлагддаг.</p>

⁷⁵ Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн Судалгааны тайлан. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол. УБ., (2007) 435-442 дахь тал

⁷⁶ Basic Act on Crime Victims. 2004.12.08. <https://bit.ly/2WyW9AZ>

⁷⁷ Япон Улсын Гэмт хэргийн цагаан ном. <https://cutt.ly/wWIRXak>

Хүснэгт 2.4-ийн үргэлжлэл

Улс орон	НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ҮНЭЛЭХ, ТҮҮНИЙГ ОЛГОХ СУБЪЕКТ
БНСУ	<p>Шууд хохирогчдоос гадна хүчирхийлэлд өртөх нь хохирогчийн ойр дотны хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Гэмтлийн шууд бус хохирогчдод үзүүлэх нөлөөг хүлээн зөвшөөрч, 2013 онд гэмтлийн дараах стрессийн эмгэг (PTSD)-ийн тодорхойлолтыг өөрчилсөн бөгөөд ойрын хамаатан эсвэл дотны найз нь гэмтэлд өртсөн болохыг мэдсэн хүмүүсийг хамруулсан болно. Нова Скотиа мужид нас барсан хүний гэр бүлийн гишүүдэд 4000 доллар хүртэлх зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлдэг.</p> <p>Нөхөн олговрын хэмжээ: Гэмтлийг 1-6 түвшинд ангилснаар нөхөн олговрын хэмжээг тогтоодог.</p> <p>Нас барсан этгээдийн гэр бүлд олгох нөхөн олговор: 30-15 сая вон</p> <ul style="list-style-type: none"> · 1-р зэргийн бэртэл: 30 сая вон · 2-р зэргийн бэртэл: 25 сая вон · 3-р зэргийн бэртэл: 20 сая вон · 4-р зэргийн бэртэл: 15 сая вон · 5-р зэргийн бэртэл: 10 сая вон · 6-р зэргийн бэртэл: 6 сая вон <p>Өргөдлийн маягтыг Цагдаагийн хэлтэс эсвэл Төрийн үйлчилгээний төвийн прокурорын газраас авах боломжтой. Хохирогч, өргөдөл гаргагчийн хэлснээр гэмт хэргийн шинжтэй үйл явдлыг цагдаа, прокурор шалгаж, баталгаажуулсан тохиолдолд өргөдлийг хянан шийдвэрлэж, нөхөн төлбөр төлөх эсэх талаар шийдвэр гаргана.</p> <p>Хохирогчид нөхөн олговор олгох хөтөлбөрийг БНСУ-ын төсвөөс санхүүжүүлдэг.⁷⁸ Нөхөн олговор дараах төрөлтэй байна:</p> <ul style="list-style-type: none"> · Хөдөлмөрийн чадвараа алдсаны тусламжийн сан 3,000,000-6,000,000 вон. Гэр бүлд туслах сан 10,000,000 вон. · Онцгой байдлын үеийн нөхөн олговор: Хөдөлмөрийн чадвараа алдсаны тусламжийн сан 1,000,000 вон. Гэр бүлд туслах сан 2,000,000 вон.

⁷⁸ Office for Victims of Crime. Directory of International Crime Victim Compensation Programs. <https://bit.ly/3BqWfty>

ДҮГНЭЛТ

Гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцоо нь сонгон судалсан улсуудын эрх зүйн тогтолцооны онцлогоос хамааран өөр байх боловч нийтлэг дараах зүйл ажиглагдаж байна. Үүнд:

1. Гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцоог баталгаажуулж, хохирол барагдуулах үйл ажиллагааг журамласан тусгайлсан хууль батлан хэрэгжүүлсэн.
2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол үнэлэх, хохирлын хэмжээг тогтоох арга хэрэгслүүд нь тодорхой.
3. Тодорхой төрлийн гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх тусгайлсан журам, аргачлалтай.
4. Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх сан, сангийн эрх зүйн байдлын талаар тусгай зохицуулалттай.
5. Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх урт, дунд, богино хугацааны хөтөлбөрүүдтэй.
6. Гэмт хэргийн хохирогчдыг дэмжих, хохирлоо барагдуулахад зөвлөгөө, туслалцаа үзүүлэх дэд бүтэцтэй.
7. Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх үйл ажиллагааны албан ёсны статистик мэдээллийн сан бүрдүүлж ашигладаг.
8. Иргэний нийгмийн халамж, даатгалд суурилсан гэмт хэргийн хохирол, хор уршгийг нөхөн сэргээх үйлчилгээтэй, гэм хорын тусгайлсан эрх зүй буюу tort law хөгжсөн.

Одоогийн байдлаар НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай факт, түүний нэмэлтээс өөрөөр хохирол барагдуулах тухай олон улсын гэрээнд Монгол Улс нэгдээгүй байна. Харин Европын холбооны гишүүн орнууд Европын холбооны хууль тогтоомжид үндэсний хууль тогтоомжийг зохих ёсоор нийцүүлэх үүрэгтэй байдаг. Европын холбоо нь гишүүн орнуудынхаа хохирлын тогтолцоог сайжруулах, хохирогчдын эрхийг нөхөн сэргээх чиглэлээр тусгайлсан стратегийн үзэл баримтлалыг батлан хэрэгжүүлдэг. Европын холбооны орнууд гэмт хэргийн хохирол үнэлэх, хохирлыг нөхөн олгохтой холбоотой өөр өөр зохицуулалттай байдаг ч Европын холбооноос гишүүн улс бүр санаатай гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох үндэсний

тогтолцоог бий болгох шаардлагыг тавьдаг.⁷⁹ Азийн бүс нутгийн хэмжээнд үйлчилдэг гэмт хэргийн хохирлын талаар эрх зүйн баримт бичиг байхгүй бөгөөд хүний эрхийг хангах талаар нэгдэн орсон баримт бичгүүдийг дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх ажил 2012-2016 он хүртэл үргэлжилсэн байна.

1. ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ ТОГТОЛЦОО

Манай улсын хувьд судлагдсан дээрх орнуудаас ялгаатай гол онцлог шүүхээс өмнө болон шүүхийн шатанд аль болох түргэн, шуурхай хандаж богино хугацаанд гэмт хэргийн хохирол, хор уршгийг төлүүлэхэд чиглэсэн байдаг. Судалсан улс орнуудын хувьд дээрх шатанд хохирол, хор уршгийг тогтоох, үнэлэх, нөхөн барагдуулах үйл явц, мөрдөн шалгах ажиллагааны төрөл, нотлох баримтын онцлог ихэнх талаараа ойролцоо байна. Харин яллагдагч, шүүгдэгч, ялтнаас гэмт хэргийн хохирол нөхөн төлөөгүй, хор уршгийг барагдуулаагүй, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоогоогүй, тухайн хэргийг илрүүлээгүй зэрэг тохиолдолд төрөөс нөхөн төлүүлэх талаар тусгайлсан хууль тогтоомж батлан гаргаж, хохирогчийг нөхөн сэргээх үйлчилгээ, дэд бүтцийг шийдвэрлэсэн нь цаашид хэрэгжүүлэх шаардлагатай алхам гэж үзлээ.

Судлагдсан орнуудын төрөөс гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх үндэслэлийг үзвэл:

- Гэмт хэрэг үйлдсэн этгээд тогтоогдоогүй буюу тухайн хэргийг илрүүлээгүй;
- Тухайн хэрэг гарсан нь тогтоогдсон, шийдвэрлэгдсэн боловч гэмт хэрэг үйлдсэн этгээдээс гэмт хэргийн хохирол, хор уршгийг нөхөн төлөөгүй;
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдээс гэмт хэргийн хохирол хор уршгийг нөхөн төлсөн боловч эрүүл мэндийн хувьд нөхөн сэргээх шаардлагатай талаар дүгнэлт, шийдвэр гарсан;
- Тодорхой төрлийн хүч хэрэглэсэн гэмт хэргийн эсхүл санаатай гэмт хэргийн хохирогч болсон зэрэг байна.

Манай улсын хувьд Засгийн газрын тусгай сангийн тухай

⁷⁹ European Union, <https://bit.ly/3gRJHnk>

хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан 21 төрлийн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дараах хохиролд нөхөн төлбөр олгохоор заасан. Үүнд: эмчилгээний зардал; оршуулгын зардал; хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого зэрэг хамаарах ба хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдоно гэжээ.

Гадаадын улс орнууд гэмт хэргийн хохирлын нөхөн төлбөр олгох үндэслэлд зөвхөн амь насаа алдсан, хүнд гэмтэл учруулсан байх гэсэн хязгаарлалт оруулаагүй бөгөөд өргөн хүрээнд тодорхойлж харин хохирогч гэмт этгээдээс хохирлоо барагдуулаагүй байх, нөхөн сэргээх шаардлагатай талаар шийдвэр гарсан байх зэрэг үр нөлөө бүхий үндэслэлүүдийг тусгасан нь цаашид Монгол Улсад гэмт хэргийн хохирлын нөхөн төлбөр олгох үндэслэл, хүрээ, хязгаарыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Дурдсан бүх улсуудад гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоохдоо тухайн улсын Эрүүгийн процессын хуульд заасан мөрдөн шалгах арга хэрэгсэл, ажиллагаануудаар тогтоодог ба харин үүний дараа үнэлэх, нөхөн төлбөрийг мөнгөн дүнгээр илэрхийлэх, нөхөн сэргээх тусламж дэмжлэг, эмчилгээ үйлчилгээг тогтоох, түүнийг үзүүлэх зэрэг асуудлыг тусгайлсан хууль, журмаар зохицуулжээ.

Гэмт хэргийн хохирогчийн эрх ашгийг хамгаалах, туслалцаа үзүүлэх тогтолцоо нь дараах бүтцийг бүрдүүлснээс шууд хамаарч байна. Үүнд:

- Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодыг төрөөс дэмжих, хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Эрүүл мэндийн байгууллага болон төрийн бусад байгууллагын уялдаа холбоог сайжруулах, тэдний дагаж мөрдөх журам, аргачлалыг тодорхой болгох;
- Дэд бүтэц буюу нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх нэгж, нэг цэгийн үйлчилгээний цэгүүд, хамгаалах байр, туслалцааны төв, түүний салбаруудыг байгуулах, төсөв санхүү, үйл ажиллагааны тогтвортой байдлыг дэмжих зэрэг болно.

Хохирогчид дэмжлэг туслалцаа үзүүлэх нь дан ганц төрийн чиг үүрэг биш бөгөөд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын дэмжлэг туслалцаатайгаар үр дүнд хүрдэг нь ажиглагдлаа.

2. ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ САН

Монгол Улсын хувьд 2014-2015 онд “Хохирлын сангийн тухай” хуулийн төслийг тухайн үеийн эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсруулан хэлэлцүүлж байсан боловч түүний эх үүсвэр болох гэмт хэрэг, зөрчлийн торгууль, түүний хүүгийн орлого нь Төсвийн тухай хуульд заасан “орон нутгийн төсвийн бус орлого”-ыг бүрдүүлдэг гэсэн шалтгаанаар дэмжлэг аваагүй, буцаагдсан байна. Судалсан орнуудын дийлэнх нь гэмт хэргийн хохирлын сангийн тусгайлсан хуультай. Иймээс Хохирлын сангийн тухай хуулийг батлан хэрэгжүүлэхдээ бүрдүүлэх байнгын эх үүсвэрийг тодорхой зааж дараа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдээс тухайн санд нөхөн төвлөрүүлдэг дараах зохицуулалт бий болгож хэрэгжүүлбэл үр дүнтэй. Үүнд:

- Сангийн эх үүсвэрийг эрүүгийн хэргийн болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны торгуулийн орлогоос бүрдэхээр заах;
- Сангийн зориулалт, нөхөн төлбөр олгох журмыг хуульчлах;
- Санд буцаан төвлөрүүлэх орлого, эх үүсвэрийг тусгах (ялтан хэрэг шийдвэрлэгдсэний дараа нөхөн төлсөн гэх мэт);
- Нөхөн олговор, төлбөрийн зарцуулалтыг хянах, үнэлэх зэрэг болно.

3. ХОХИРОЛ, ХОР УРШИГ ТООЦОХ, ҮНЭЛЭХ, БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ

Гэмт хэргийн улмаас хөрөнгө, эрүүл мэндэд учирсан хохирлыг тогтоох, үнэлэх үндэслэл журмыг ихэнх улс орнууд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой зааж зохицуулж байна. Энэ нь манай улсын эрх зүйн зохицуулалтаас хол зөрөхгүй боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхээс өмнөх шатны шийдвэрийг шууд үнэлэн нөхөн төлбөр олгох, зарим хохирлыг тогтоох, үнэлэх

журмыг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд иш татан зааж өгчээ.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд зарим улс (ХБНГУ, Япон Улс) гэмт хэргийн сэтгэл санааны хохирлыг бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, бэлгийн эрх чөлөө зэрэг эрх, ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд гаргуулж байна. Өөрөөр хэлбэл, тодорхой гэмт хэргийг нэрлэн заахгүй харин хөндөгдсөн эрх, эрх ашгийг тодорхой зааж, гэмт хэрэг үйлдсэн этгээд учруулсан хохирол, хор уршгаа нөхөн төлөөгүй эсхүл зарим хэсгийг төлсөн байх гэх мэт үндэслэлийг тусган хэрэгжүүлж болохоор байна.

Мөн ихэнх улс орон нь эрүүгийн хэргийн шүүхийн өмнөх шатны шийдвэр (хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн гэх мэт)-ийг шууд үндэслэл болгон нөхөн төлбөр олгодог бол манай Улсын хувьд зөвхөн шүүхийн шийдвэр гарсны дараагаар нөхөн төлбөр олгох зохицуулалттай байгаа нь учир дутагдалтай юм.

Гэмт хэргийн улмаас эдийн хөрөнгийн бус хохирол, сэтгэл санааны хохирлыг хэрхэн тогтоож, үнэлэх талаар тусгайлсан зохицуулалт, журам аргачлал байхгүй нь манай улсын хувьд том сорилт болж байсан. Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж 2023 онд Шүүх шинжилгээний тухай хуулийг батлан гаргахдаа Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар шийдсэн нь цаашдаа хохирогчийн хувьд шийдвэр гаргах процесс илүү урт болох эрсдэлтэй гэж дүгнэж байна. Учир нь Эрүүгийн хэргийг шийдвэрлэсний дараагаар иргэний журмаар нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлүүлэхэд хоёр дахин урт хугацаа шаардагдах болно.

Цаашдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоох, үнэлэхтэй холбоотой тусгай бүлэг зохицуулалтыг тусгах хэрэгцээ байгаа нь тодорхой юм. Иймд эрүүл мэндийн хохирлыг үнэлэх аргачлалыг шинэчлэх, мөн эд эрхтний үнэлгээний жишиг аргачлал, дундаж үнэлгээг итгэлцүүрээр тогтоож байх, сэтгэл санааны хохирлыг үнэлэх арга, аргачлалыг батлахдаа дээр дурдсан улс орнуудын туршлагаас харгалзан үзэх нь зүйтэй байна.

4. МОНГОЛ УЛС ДАХЬ ХОХИРОЛ ТОГТООХ, ҮНЭЛЭХ, НӨХӨН ТӨЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭТГЭЛ

Шүүх шинжилгээний тухай хууль: Гэмт хэргийн хохирол, хор уршгийн нэг хэлбэр болох сэтгэл санааны хохирлыг тогтоох, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүхийн шинжилгээ хийхтэй холбоотой зохицуулалттай нийцүүлэх зэрэг олон шаардлагын улмаас дээрх хуулийг шинэчлэн баталсан байна.

Энэхүү хуулийн шинэчилсэн найруулга нь 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Шинэчилсэн найруулгаар сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох, үнэлгээнд шинжилгээ хийх зохицуулалтыг нэмж өгснөөрөө онцлогтой байна. Уг хуулийн 40 дүгээр зүйлээр Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох үнэлгээг зохицуулсан. Ингэхдээ дараах нөхцөлийг харгалзан үзэхээр тусгасан:

- 40.2.1.хохирогч нь энэ хуулийн 40.1-д заасан гэмт хэргийн хохирогч байх, эсхүл хохирогч нас барсан бол хохирогчийн гэр бүлийн гишүүн байх;
- 40.2.2.энэ хуулийн 40.1-д заасан гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэцэд түр зуурын, эсхүл байнгын шинжтэй өөрчлөлт орсон байх;
- 40.2.3.хохирогчийн сэтгэцэд учирсан хямрал, эмгэгийг сэтгэцийн шинжилгээгээр тогтоосон байх.

Хүснэгт 3.1. Шүүх шинжилгээний тухай өмнөх ба шинээр батлагдсан хуулийн харьцуулалт

№	Шинэчилсэн найруулга (Шүүх шинжилгээний тухай (2023))	Өмнөх хууль (Шүүхийн шинжилгээний тухай (2009))	Онцлог
1	Шүүх шинжилгээ хийх үндэслэлийг Хоёрдугаар бүлэг рүү шилжүүлж нийтлэг журамтай нийлүүлсэн.	Шүүхийн шинжилгээ хийх үндэслэл нь Нэгдүгээр бүлэг болох Нийтлэг үндэслэлийн 5 дугаар заалт байсан.	Шинэчилсэн найруулга 11 бүлэг, 81 зүйлтэй бол Өмнөх хууль 6 бүлэг 45 зүйлтэй.

Хүснэгт 3.1-ийн үргэлжлэл

№	Шинэчилсэн найруулга (Шүүх шинжилгээний тухай (2023))	Өмнөх хууль (Шүүхийн шинжилгээний тухай (2009))	Онцлог
2	8 дугаар зүйлд шүүх шинжилгээ хийх этгээдийг тусгасан.	12 дугаар зүйлд шинжилгээ хийх журмыг тусгасан.	Шинэчилсэн найруулгын шинжилгээ хийх үндэслэлд “арбитрын тогтоол” нэмж оруулсан.
3	11 дүгээр зүйлээр шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох зохицуулалтыг оруулсан.	19 дүгээр зүйл. Нэмэлт шинжилгээ хийх.	Лицензийн тогтолцоонд шилжиж байгаа ба энэ нь хариуцлага тооцох, чадавхжуулах, хүний нөөцийг дэмжихэд ач холбогдолтой.
4	13 дугаар зүйлээр шинжилгээний объектыг шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах зохицуулалтыг оруулсан.	20 дугаар зүйл. Дахин шинжилгээ хийх.	Өмнө байсан зохицуулалтыг боловсронгуй болгож, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхийг зорьсон.
5	15 дугаар зүйлд шинжилгээний стандартыг тусгасан.	21 дүгээр зүйл. Шинжилгээг бүрэлдэхүүнээр хийх.	
6	Шинжээчийн эрх, үүрэг, хориглох зүйлийг Шинжилгээнд оролцогч гэх тусдаа бүлэг рүү шилжүүлсэн.	22 дугаар зүйл. Ижил мэргэжлийн шинжээчдийн бүрэлдэхүүнтэйгээр шинжилгээ хийх.	Оролцогчдыг ялгаж, эрх үүргийг тодорхой болгосон.
7	20 дугаар зүйл. Шинжилгээний нууцлал.	23 дугаар зүйл. Өөр өөр мэргэжлийн шинжээчдийн бүрэлдэхүүнтэй шинжилгээ хийх	Хүний эрхийг хангах үүднээс шинжилгээтэй холбоотой нууцлалын талаар шинээр тусгасан.

Хүснэгт 3.1-ийн үргэлжлэл

№	Шинэчилсэн найруулга (Шүүх шинжилгээний тухай (2023))	Өмнөх хууль (Шүүхийн шинжилгээний тухай (2009))	Онцлог
8	21 дүгээр зүйл. Шинжилгээний хураамж, зардал	32. Цагдан хоригдоогүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид сэтгэцийн шинжилгээ хийх.	Төлбөрийн чадваргүй болон оролцогчдоос төлөх шинжилгээний зардлыг ойлгомжтой оруулсан.
9	Гуравдугаар бүлэг. Шинжилгээний адилтгал, мэдээллийн сан, түүний төрөл, бүрдүүлэлт, ашиглалт, хамгаалалт	33. Цагдан хоригдож байгаа этгээдэд сэтгэцийн шинжилгээ хийх.	Шинжилгээний сан бий болгож түүнийг үйл ажиллагаандаа ашиглах талаар заасан нь шинэлэг алхам болсон.
10	Дөрөвдүгээр бүлэг. Шинжилгээний хэлбэр	34. Яллагдагч, шүүгдэгчийн өмнө “Сэжигтэн” гэдэг үг байсан.	
11	Тавдугаар бүлэг. Зарим шинжилгээний онцлог нь өмнөх хуулийн гуравдугаар бүлэгтэй адил агуулгатай боловч нэмэлт зарим шинжилгээ тусгагдсан байна. Үүнд 35. Хөрөнгийн үнэлгээний шинжилгээ, 36. Цахим технологийн шинжилгээ, 37. Инженер-техникийн шинжилгээ, 38. Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ, 40. Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох үнэлгээ орно.	39. Шүүхийн шинжилгээний байгууллагын санхүүжилт ганц зүйлээр зохицуулагдаж байсан.	Шинжилгээний төрлүүдийг шинээр тодорхойлж, түүнийг тогтоох, үнэлэх талаар тодорхой болгосон нь өмнөхөөс ахисан алхам болсон.

Хүснэгт 3.1-ийн үргэлжлэл

№	Шинэчилсэн найруулга (Шүүх шинжилгээний тухай (2023))	Өмнөх хууль (Шүүхийн шинжилгээний тухай (2009))	Онцлог
12	46 дугаар зүйл. Хүний биед хийх шинжилгээний аргад тавих хязгаарлалт	40. Шүүхийн шинжилгээний мэдээллийн сан тусдаа бүлэг биш, ганц зүйл байсан.	
13	Аравдугаар бүлэг. Шинжилгээний байгууллагын санхүүжилт тусдаа бүлэг болсон ба шинжилгээний байгууллагын төсөв, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх хоёрыг зааглан үзсэн.		
14	80. Шилжилтийн үеийн зохицуулалт		
15	81. Хууль хүчин төгөлдөр болох		

Иргэний хууль: Шүүх шинжилгээний тухай хууль батлагдсантай холбогдуулан Иргэний хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг тусгажээ. Үүнд:

- “230.2.Сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгах бөгөөд бусад эдийн бус гэм хорыг гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр арилгана.”
- 508 дугаар зүйлийн 508.5 дахь хэсэг:
- “508.5.Гэмт хэргийн улмаас нас барсан иргэний хамт амьдарч байсан гэр бүлийн насанд хүрсэн гишүүн эсхүл насанд хүрээгүй гишүүний хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээд нь өөрийн сэтгэцэд учирсан гэм хорыг арилгуулахыг шаардах эрхтэй.”
- 511 дүгээр зүйлийн 511.3-511.5 дахь хэсэг:
 - “511.3.Энэ хуулийн 230.2-т заасан сэтгэцэд учруулсан гэм

хорыг мөнгөн хэлбэрээр арилгах үүргийг гэм хор учруулсан этгээд хүлээнэ.

- 511.4.Гэмт хэргийн улмаас бүтэн өнчин болсон бага насны хүүхдийн сэтгэцэд учирсан гэм хорыг арилгах, нөхөн төлөх төлбөрийн хэмжээг насанд хүрсэн хүний сэтгэцэд учирсан гэм хорыг арилгах, нөхөн төлөх төлбөрийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж тогтооно.
- 511.5.Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүний сэтгэцэд учирсан гэм хорыг арилгах, нөхөн төлөх төлбөрийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр эсхүл нас барсан хүний нас, хүн амын дундаж наслалтын зөрүүг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр үржүүлэн хохирогчид аль ашигтайгаар шүүхээс тогтооно.”
- Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийн “эрүүл мэнд,” гэсний дараа “сэтгэцэд,” гэж, 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсгийн “зардал болон” гэсний дараа “энэ хуулийн 508.5-д зааснаас бусад” гэж нэмсэн байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Гадаад орнуудын гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцоог харьцуулан судалсны үндсэн дээр Монгол Улсад гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцоо, түүнийг үр дүнтэй ажиллуулахад чиглэгдсэн дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Гэмт хэргийн хохирлын нөхөн төлүүлэх тогтолцоог бүрдүүлсэн эрх зүйн орчныг бий болгох, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд хохирогчийн хохирлыг барагдуулах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг илүү тодорхой болгох;
2. Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх сангийн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, Гэмт хэргийн хохирлын сангийн тухай хуулийг боловсруулж, түүнийг бүрдүүлэх эх үүсвэрийг зааж, батлан хэрэгжүүлэх;
3. Гэмт хэргийн хохирлыг үнэлэх, хохирлын хэмжээг тогтоох, хохирол нөхөн барагдуулах журам, аргачлалыг боловсруулах, ингэхдээ олон улсын жишиг аргачлал, зөвлөмжүүдийг харгалзан үзэх;
4. Гэмт хэргийн хохирол, хор уршгийг төрөөс нөхөн төлүүлэх тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх;
5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг үнэлэх, түүний хэмжээг мөнгөн дүнгээр тогтоох шүүхийн практикийг хэвшүүлэх;
6. Гэмт хэргийн хохирогчдыг дэмжих, хохирлоо барагдуулахад зөвлөгөө, туслалцаа үзүүлэх;
7. Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх үйл ажиллагааны албан ёсны статистик мэдээллийг тогтмолжуулах, мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах;
8. Шинээр батлагдсан Шүүхийн шинжилгээний тухай хуульд эрх бүхий субъектээс батлахаар заасан тодорхой аргачлал буюу

захиргааны хэм хэмжээний актыг боловсруулахдаа дурдсан орнуудын аргачлалыг ашиглах, олон улсын сэтгэцийн өвчний ангилал, жагсаалтыг жагсаалтыг ашиглах;

9. Шүүх шинжилгээний байгууллагын бүтцэд сэтгэл санааны хохирол үнэлэх тусгайлсан нэгж байгуулахаас илүүтэй хохирол үнэлэх аргачлалаа ойлгомжтой баталж, орон нутагт тухайн аргачлалыг хэрэглэж сэтгэл санааны хохирлыг тогтоох боломжтой байхаар тогтолцоог бүрдүүлэх;
10. Хууль сахиулагч буюу мөрдөгчийн ажил дүгнэх үзүүлэлтийг агуулгаар нь өөрчилж, гэрч хохирогчийг хамгаалах шийдвэр гаргасан, хохирогчийг шаардлагатай тусламж үйлчилгээнд холбон зуучилсан зэрэг шалгуурыг нэмж оруулах.

Судалгаанд хамрагдсан гадаад орнуудын гэмт хэргийн хохирол барагдуулах тогтолцооны онцлогийг судлах явцад манай эрх зүйн онцлогтой ойролцоо, хүний эрхийг дээдэлсэн Европын холбооны стандартад нийцсэн ХБНГУ-ын эрх зүйн орчин, Англо-саксон, Ром-германы эрх зүйн тогтолцооны аль алины онцлогийг нэгтгэн хэрэгжүүлж буй БНСУ-ын туршлагыг гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй гэж үзлээ. Ингэхдээ төрөөс баримтлах бодлого, хэрэгжүүлж буй хөтөлбөр, түүний үр дүнг үнэлж буй байдал, эрүүгийн шүүхийн тогтолцоо дахь хохирлыг үнэлэх, нөхөн төлүүлэх ажиллагаа, түүнчлэн энэ ажиллагаа иргэний журмаар хянан шийдвэрлэх онцлог зэрэгтэй уялдуулан цогцоор судлах нь илүү үр дүнтэй. Түүнчлэн даатгалын тогтолцоо болон хохирол нөхөн төлүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх цогц үйл ажиллагааг ч хамруулах нь зүйтэй.

Судалсан Улс орнуудын эрүүгийн процессын тогтолцоо, хөгжлийн чиг хандлагаас үзвэл Монгол Улс хоцроогүй боловч гэмт хэргийн хохирлыг төрөөс нөхөн барагдуулах(гэм буруутай этгээдээс нөхөн төлөөгүй тохиолдолд), сангаар дамжуулан хохирогчдод туслах, үйлчлэх зэрэг дараагийн шатанд шилжих шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь Судалгааны үндсэн болон хавсралт тайлан (Хамтын бүтээл), 2016.
2. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол. УБ. 2007.
3. Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт. Суурин дүн шинжилгээ, 2013.
4. Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоо, (Судалгааны тайлан), 2010.
5. Нээлттэй Нийгэм Форум, Монголын Криминологичдын холбоо, Хохирлын үндэсний тогтолцоо. Монгол Улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал, Цуврал судалгаа №1.
6. COUNCIL DIRECTIVE 2004/80/EC of 29 April 2004 relating to compensation to crime victims,
7. Council of Europe. European Convention on the Compensation of Victims of Violent Crimes. 1983.
8. Victim Support Europe, The Criminal Justice Programme of the European Union. Handbook for Implementation of Legislation and Best Practice for Victims of Crime in Europe. 2013.
9. United Nations. Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power. 1985.
10. Victim Support Europe, The Criminal Justice Programme of the European Union. Handbook for Implementation of Legislation and Best Practice for Victims of Crime in Europe. 2013.

ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ

1. https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Court%20Series%204_Web.pdf
2. www.legalinfo.mn
3. Germany. <https://bit.ly/3DBXOqo>
4. Federal Ministry of Justice. Basic Law for the Federal Republic of Germany. <https://bit.ly/3t3iVwS>
5. Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хууль. (1987) https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1
6. Korea Certified Valuation Analyst (KCVA), Legal Service and Victim Support Division, Ministry of Justice. Гэмт хэргийн хохирогчийн гарын авлага (A guide for Crime Victims) <https://www.korea.kr/common/download.do?tblKey=EDN&fileId=181614>
7. Gesetz über die Entschädigung für Strafverfolgungsmaßnahmen (StrEG) <https://bit.ly/3Dz3x06>
8. Fact sheet: Germany. <https://bit.ly/3DCLt5h>
9. Act on compensation to victims of violent crime, (Crime Victims Compensation Act – OEG) <https://bit.ly/3jxavuy>
10. DUNKEL, F. (1985). Victim Compensation and Offender Restitution in the Federal Republic of Germany—A Western-European Comparative Perspective. *International Journal of Comparative and Applied Criminal Justice*, 9(1-2), 29-39. <https://doi.org/10.1080/01924036.1985.9688805>
11. ODABS. Benefits via the Crime Victims Compensation Act. <https://bit.ly/3t3f9Uh>
12. <https://weisser-ring.de/english>
13. Code of Criminal Procedure, StPO <https://bit.ly/3yJ2xTP>
14. Weisser-ring. <https://bit.ly/3zzhR6B>
15. Jehle, J. M. (2019). *Criminal justice in Germany: facts and figures*. Forum Verlag Godesberg GmbH.
16. “Польшийн Хуулийн сэтгүүл”, 79-р зүйл, 2009 Польшийн Сэтгэл Судлалын Холбооны дэргэдэх Эрүүл мэндийн сэтгэл судлалын хүрээлэн
17. Implementing victim-oriented reform of the criminal justice sys-

- tem in the European Union. Hungary. Developments on the implementation of victim assistance mechanisms. https://www.apav.pt/ivor/images/ivor/PDFs/Fact_sheet_hungary.pdf
18. Ito Fujie, Ishii-Takiguchi Ryoko. The Current Status and Issues in Crime Victim Support in Japan. (2020.06) http://www.sophia-humans.jp/departments/socialservices_bulletin/pdf/2020_06.pdf
 19. 犯罪被害者等基本法.Basic Act on Crime Victims. 2004.12.08 <https://bit.ly/2WFX9mK>
 20. Korea Certified Valuation Analyst (KCVA), Legal Service and Victim Support Division, Ministry of Justice. Гэмт хэргийн хохирогчийн гарын авлага (A guide for Crime Victims) <https://www.korea.kr/common/download.do?tblKey=EDN&fileId=181620>
 21. <https://bit.ly/3kJL6gz>, Act on compensation to victims of violent crime, (Crime Victims Compensation Act – OEG)Assistance to Victims of Crime in Poland selected. issuesprovidus.lv/upload_file/Projekti/Kriminalitesibas/Victim_support/5.PL.pdf · Assistance to Victims of Crime in Poland – - [PDF Document] (documents.pub)
 22. <https://www.riigiteataja.ee/en/eli/521122013001/>
 23. <https://providus.lv/wp-content/uploads/2021/07/4.-HU.pdf> Crime Victim Support and State Compensation Act (Victim Support Act 2005) Hungary
 24. Victims of Crime Implementation Analysis of Rights in Europe. National report of Hungary. (2019) p.20 https://victimsupport.eu/activeapp/wp-content/uploads/2019/08/VOCIARE_National_Report_Hungary_interactive.pdf
 25. https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=33075&lang=ENG (Crime victim protection fund act)
 26. БНСУ-ын эрх зүйн мэдээллийн систем. <https://bit.ly/2Wz17y9>
 27. Закон о борьбе против торговли людьми (трефикинга) (2006.04.28) Вебсайт Государственного фонда. <http://www.atipfund.gov.ge/index.aspx>
 28. Карим Восток – Консорциум прикладных исследований по международной миграции. Натия Челидзе. Торговля людьми:

- Грузия. Пояснительная записка 13/34. Социально-политические рамки миграции. (2013)
29. https://cadmus.eui.eu/bitstream/handle/1814/62796/Explanatory%20Notes_2013-34.pdf?sequence=1&isAllowed=y
 30. Crime Victim Support of Japanese <https://bit.ly/3ngsBTS>; <https://bit.ly/3DYX270>; <https://bit.ly/3hfSMWZ>
 31. Victim services. <https://www.justice.gov.nt.ca/en/victim-services/>
 32. Правительство РФ призвали создать фонд помощи жертвам преступления. (2020.02.26) <https://regnum.ru/news/2868270.html>
 33. Info Victims. Country Profile: Germany <http://www.infovictims.com>
 34. European Network on Victims' Rights. Hungary. <https://envre.eu/hungary/>
 35. Гүрж Улсын Иргэний хууль. (1997.07.24) <https://matsne.gov.ge/en/document/view/31702>
 36. Би гэмт хэргийн хохирогчийн хувьд ямар эрхтэй вэ? <https://bit.ly/3DDJqOG>
 37. Эрделевский А.М “Компенсация морального вреда” Москва, Издательство БЕК, 2000 он, 61 дэх тал
 38. Swissre. Bodily injury landscape Europe: Germany (2018) <https://bit.ly/3mQyHKs>
 39. F.F.Blachly & M.E.Oatman, Approaches to Governmental Liability in Tort: A Comparative Survey, 9 Law and Contemporary Problems 181-213 (Spring 1942).
 40. Закон Грузии О борьбе против торговли людьми (трефикинга). (2006.04.28) <https://bit.ly/3kFARds>
 41. О пресечении насилия в семье, защите и оказании помощи жертвам насилия в семье (2006) <https://bit.ly/38uamlt>
 42. Basic Act on Crime Victims. 2004.12.08. <https://bit.ly/2WyW9AZ>
 43. Япон Улсын Гэмт хэргийн цагаан ном. <https://cutt.ly/wWIRXak>
 44. Office for Victims of Crime. Directory of International Crime Victim Compensation Programs. <https://bit.ly/3BqWfty>

ISBN 991999905-9



9 789919 999905